



Empowered lives.  
Resilient nations.

## Тэнцвэртэй тогтвортой өсөлт

2012-2016 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр,  
Монгол Улсын Засгийн газар хамтран  
хэрэгжүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагааны  
төлөвлөгөө

## ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТАЙЛАН – 2012-2013



Улаанбаатар  
2014 оны 2 дугаар сар

## Өмнөтгөл

Хөгжлийн Тусламжийн Хүрээ (НҮБХТХ) болон Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн (НҮБХХ) Гүйцэтгэх зөвлөлийн баталсан Улс орны хөтөлбөрийн баримт бичиг (УОХББ) дээр үндэслэн Тусламжийн хөтөлбөрийн Үйл ажиллагааны төлөвлөгөөг (ТХҮАТ) боловсруулав. НҮБХТХ, УОХББ, болон ТХҮАТ-г тухайн улсын хөгжлийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, үнэлгээ, өмнөх туршлага дээр тулгуурлан олон талуудын оролцоотойгоор боловсруулдаг.

НҮБХТХ нь Засгийн Газар болон Нэгдсэн Үндэстний Байгууллага хоорондын хамтын ажиллагааны стратегийн чиглэл, хүрэх үр дүнг тодорхойлдог бол УОХББ нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд оруулах НҮБХХ-ийн хувь нэмрийг онцолж, ТХҮАТ нь НҮБХХ-ийн хөтөлбөрийн хэрэгжилт, зохицуулалт тал дээр илүү анхаарч, хүрэх үр дүнг дэлгэрэнгүй тодорхойлсон болно. ТХҮАТ дээр үндэслэн төслийн баримт бичгүүд, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулдаг.

Энэ тайланд хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний хоёр жилийн явцыг (2012 болон 2013) хамруулав. Тайлангийн зорилго нь одоо гараад буй ахиц дэвшил дээр үндэслэн дүн шинжилгээ хийж, Монгол улсын хөгжлийн чиг хандлагатай хөтөлбөрийн чиглэлийг нийцүүлэх, хөтөлбөрийг сайжруулах талаар авч буй арга хэмжээг танилцуулах явдал юм. Энэхүү тайлан нь НҮБХХ болон Монгол улсын хамтын үйл ажиллагааг улам үр дүнтэй болгох, энэ чиглэлээр авч болох арга хэмжээнүүдийг тусгах зэргээр хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх суурь бичиг баримт болно.

## Агуулга

<b>I. Хөгжлийн чиг хандлага .....</b>	<b>3</b>
<b>II. НҮБХХ-ийн хөтөлбөрт гарсан өөрчлөлтүүд .....</b>	<b>4</b>
<b>III. Хөгжлийн зорилтуудын хэрэгжилт .....</b>	<b>5</b>
Ядуурлыг бууруулах болон МХЗ-уудыг хангах хүрээнд хэрэгжүүлж буй ажлын явц.....	6
Ардчилсан засаглалын хүрээнд хэрэгжүүлж буй ажлын явц.....	8
Байгаль орчин ба тогтвортой хөгжлийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлын явц.....	10
<b>IV. Хөндлөнгийн үнэлгээний тайлан ба аудитын зөвлөмжүүд .....</b>	<b>13</b>
<b>V. Хэрэгжилтийн явц.....</b>	<b>15</b>
<b>VI. Дүгнэлт ба зөвлөмж .....</b>	<b>16</b>

## Хөгжлийн чиг хандлага

Монгол улсын хөгжлийн чиг хандлага эерэг байгаа бөгөөд Засгийн газраас хөгжлийн үйл явцад сайнаар нөлөөлөхүйц хэд хэдэн гол арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Ерөнхийдөө, эдийн засаг хоёр оронтой тоогоор өсөж, 2013 оны эцсийн байдлаар өсөлтийн хувь 12.3%-тай байв. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2006 онд 300 ам.доллар байсан бол 2012 оны эцэс гэхэд ойролцоогоор 3400 ам.доллар болж нэмэгдсэн ба Монгол Улс өдгөө Дэлхийн Банкны ангилалаар дундажаас доогуур орлоготой орнуудын бүлэгт харьяалагдах болжээ. Монгол улсын хүний хөгжлийн индекс (ХХИ) 0,675 болсноор 187 орнуудаас 108-р дугаарт жагсаж НҮБХХ-ийн зүгээс дундаж хөгжилтэй орны ангилалд багтаж байна. 2010-2012 оны хооронд ядуурлын түвшин 11-ээс дээш хувиар буурчээ. Монгол улс нийгмийн халамжийн өргөн тогтолцоотой ба энэ нь ихэнхдээ өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон оюутан гэсэн тодорхой бүлэг хүмүүст чиглэгдсэн байдаг. Монгол улс 2012 онд Улсын Их Хурлын болон орон нутгийн, 2013 онд Ерөнхийлөгчийн сонгуулийг амжилттай, тайван замаар зохион байгууллаа. Засгийн газрын ил тод байдал болон мэдээллийн эрх чөлөө сайжирснаар Монгол улс олон улсын авилгын үзүүлэлтээр 2011 онд 120 байснаа 2012 онд 94, 2013 онд 83 болж дээшилжээ. Монгол улс Дэлхийн Эдийн Засгийн Форумын тодорхойлсон жендэрийн индексээр 2007 онд 128 орноос 62-т бичигдэж байсан бол 2013 онд 135 орноос 33-т бичигдэж сайжирсан үзүүлэлттэй байна.

Хүн ам ихээр хотжиж 67.2% нь хот суурин газар оршин сууж байгаагаас 46% нь зөвхөн Улаанбаатар хотод амьдран сууж байна. Монгол Улсын Засгийн газар 2012 онд зохион байгуулагдсан Рио+20 НҮБ-ын Бага хурал, 2013 оны 6 дугаар сард Монголд зохион байгуулагдсан Дэлхийн байгаль орчны өдрийг тус тус тэмдэглэн өнгөрүүлсэн арга хэмжээний дараа тогтвортой хөгжил болон ядуурлыг бууруулах ногоон хөгжлийн стратегийг боловсруулсан.

Хүний хөгжлийг тогтвортой хангах зорилгын үүднээс харахад Монгол улсад хөгжлийн үндсэн бэрхшээл, асуудлууд байсаар байна. Эдийн засгийн өсөлт өндөртэй ч ядуурал хэвээр буюу 27.4% байгаа нь тэгш бус байдал улам бүр нэмэгдэж байгааг илтгэж байна. Ядуурал нь олон хүчин зүйлээс хамааралтай тул дан ганц Дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) үзүүлэлтээр хэмжих нь тохиромжгүй. Хүн амын эмзэг бүлэгт чиглэсэн, зорилтот байдлаар хандсан ядуурлыг бууруулах бодлоготой байх нь үр дүнтэй арга зам болно. Уул уурхайн баялаг болон орлогоос дагнасан хамааралтай байх нь Монгол улсыг гадаад орчны тогтворгүй байдалд өртөмтгий болгож байна. Тиймээс төрөлжүүлэлт нэн чухал юм. Уул уурхайн салбарын өсөлт нь Монгол улсын эмзэг эко-системд нэмэлт дарамт учруулж байна. Агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгаралт ихтэй эрчим хүчний үр ашиггүй байдал, нийгмийн үйлчилгээний хүртээмж дутмаг, хотын захын хорооллууд төлөвлөлтгүй улам ихээр тэлж байгаа зэрэг нь тулгарч буй гол асуудлуудын зөвхөн зарим хэсэг юм.

Байгалийн гамшигт үзэгдлүүд Монголд ихээр гарах болсон нь орон нутаг, эмзэг бүлгийн хүмүүст хүндээр тусч байна. Уур амьсгалын өөрчлөлт нь цөлжилтийг эрчимжүүлэх, бэлчээрийн биологийн тэнцвэрт байдал алдагдах эрсдлийг нэмэгдүүлж байна.

## НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрт гарсан өөрчлөлтүүд

Дор дурдсан өөрчлөлтүүд нь 2012-2016 оны НҮБХХ-ийн тусламжийн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд (ТХҮАТ) тусгасан төсөл хөтөлбөрүүд түүнчлэн тэдгээрийн 2014 он болон түүнээс цааших жилийн ажлын төлөвлөгөөнд нөлөөлнж байна. Эдгээр өөрчлөлт НҮБ-ын гишүүн улсуудын оролцон баталдаг НҮБХХ-ийн Гүйцэтгэх Зөвлөлийн гаргасан шийдвэр юм.

Гол өөрчлөлтүүдийг дурдвал:

2014-2017 онд хэрэгжих НҮБХХ-ийн шинэ Стратеги төлөвлөгөө 2013 оны 9 сард батлагдсан. НҮБХХ-ийн бүх улс орны хөтөлбөрүүд энэ стратегийн төлөвлөгөөтэй нийцэж байх ёстой. Энэ бичиг баримтанд зорилтот бүлэг буюу төслийн үр шимийг хүртэгчдийг илүү тодорхой томьёолох, тэдэнд бодитойгоор хүрч ажиллах дээр анхаарлаа хандуулах талаар тусгайлан заасан байна. Түүнчлэн урьд өмнөх амжилттай хэрэгжсэн ажил, сайн туршлагыг өргөжүүлэн дэлгэрүүлэх стратеги бодлого боловсруулах тухай тусгасан байна. НҮБХХ нь бүхий л төсөл хөтөлбөрийнхөө хүрээнд баримт мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргах, үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх ажилд улам бүр анхаарлаа хандуулах боллоо. Үүнээс гадна НҮБХХ үндэсний түнш байгууллагуудтай хамтран ажиллах явцад хүрсэн нэгдсэн үр дүнг олон нийтэд илүү тодорхой харуулах, танилцуулах ажилд тусгайлан анхаарлаа хандуулахаар төлөвлөж байна. Мөн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилтыг эдгээр тогтолцоо, механизмд тусган бэхжүүлэх тал дээр анхаарна.

НҮБХХ-ийн шинээр батлагдсан стратегийн төлөвлөгөөний хүрээнд нэгдсэн үр дүн, нөөцийг томьёолсон матрикс болон зардал нөхөх бодлогын бичиг баримтыг боловсруулсан. Үүнтэй холбогдуулан, өмнө мөрдөгдөж байсан дэмжих үйлчилгээний 3% стандарт төлбөрийн хэлбэрийг илүү ил тод, сайжруулсан аргачлалыг тусгасан төслийн өртөг тооцох бодлогын бичиг баримтаар солих шийдвэр гарсан. Энэ бодлогын хүрээнд төслийн шууд хэрэгжүүлэлттэй холбогдон гарсан зардлыг (үүнд төслийн шууд хэрэгжилтэнд оролцож байгаа НҮБХХ-ийн ажилтнуудын болон үйлчилгээ үзүүлэхэд гарсан зардал зэргийг хамруулан тооцно) нөхөн тооцох аргачлалыг нэвтрүүлсэн.

Дэлхийн санхүүгийн нөхцөл байдал хүндэрснээс шалтгаалан, НҮБХХ төлөвлөж байснаас бага хэмжээний санхүүгийн эх үүсвэр, нөөц хүлээн авсан бөгөөд үүнээс улбаалан Монгол дахь НҮБХХ төсөл хөтөлбөрүүдийн төсөв болон байгууллагын үрсгал зардлаа танах шаардлагатай боллоо. Батлагдсан төсөл, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж нэгэнт төлөвлөсөн зардлуудыг аль болох гаргах тал дээр анхааран ажиллана.

Мөн түүнчлэн НҮБХХ-ийн зүгээс төсөл хэрэгжүүлэх арга болон холбогдох зохицуулалтын талаар эргэн нягталж үзлээ. Эдгээрийг НҮБХХ-ийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх төслийн удирдамж, журамд тусгасан. Энд төсөл хэрэгжүүлэх дөрвөн үндсэн аргыг тодорхойлсон нь үндэсний хэрэгжилтийн арга, иргэний нийгмийн байгууллага төсөл хэрэгжүүлэх арга, НҮБ-ын системийн байгууллага төсөл хэрэгжүүлэх арга болон НҮБХХ төсөл хэрэгжүүлэх буюу шууд хэрэгжүүлэх зэрэг арга замууд байна.

Үндэсний хэрэгжилтийн аргын хүрээнд НҮБХХ нь хэрэгжүүлэгч түнш байгууллага болон хэсэг үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж буй талд дэмжлэг үйлчилгээ үзүүлж болох бөгөөд энэ тохиолдолд НҮБХХ-ийн дүрэм, журмыг бүрэн дагана. Засгийн газраас төсөл хэрэгжүүлэх үед, засгийн газрын дүрэм, журам мөрдөгдөх ёстой. Ямар ч тохиолдолд, эдгээр дүрэм журмыг холих учиргүй. Тус удирдамж, журмуудын хүрээнд, хамгийн сайн хэрэгжилтийн аргыг сонгон тодорхойлохын тулд төсөл хэрэгжүүлэх боломжтой байгууллагуудад эхлээд үнэлгээ хийдэг.

Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хариуцлагыг бэхжүүлэх, үндэсний тогтолцоог түлхүү ашиглах зорилгоор НҮБХХ, НҮБ-ын Хүүхдийн Сан (НҮБХС) болон НҮБ-ын Хүн Амын Сан (НҮБХАС) хамтран Хэрэгжүүлэгч түнш байгууллагуудад бэлэн мөнгө шилжүүлэх уялдаа холбоо бүхий аргачлалыг хэрэгжүүлж байгаа болно.

Энэ хүрээнд, НҮБХХ, НҮБХС, НҮБХАС-ын төсөл хэрэгжүүлэгч түнш байгууллагуудын санхүүгийн системд үнэлгээ хийгдэх бөгөөд энэ нь төслийн хүрээнд бэлэн мөнгө шилжүүлэх хамгийн оновчтой аргыг тогтоох, үүнтэй холбогдуулан хяналтын үйл ажиллагааг тодорхойлох зорилготой юм. Тус үнэлгээний зардал нь тухайн төслийн төсвөөс гарна.

## **Хөгжлийн зорилтуудын хэрэгжилт**

НҮБХХ болон Монгол улсын Засгийн газар хоорондын бүтээлч, нягт хамтын ажиллагааны үр дүнд ТХҮАТ нь төлөвлөсөн үр дүнгийн хүрээнд амжилттай хэрэгжиж Монгол улсын хөгжлийн зорилтуудад хувь нэмрээ оруулж байна. Ядуурлыг бууруулах ба Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хангах нь НҮБХХ-ийн эрхэм зорилго юм. Мөн түүнчлэн Ардчилсан засаглал, хүрээлэн буй орчин, тогтвортой хөгжлийн асуудлууд дээр онцгой анхааран хөтөлбөр хэрэгжүүлдэг. ТХҮАТ нь Монгол улсын хөгжилд хувь нэмрээ оруулах ач холбогдол бүхий баримт бичиг бөгөөд хөгжлийн үйл явцад НҮБХХ-ийн дэмжлэг туслалцаа чухал байр суурь эзэлсэн хэвээр байна гэж дүгнэлээ.

Тайлангийн дараагийн бүлэгт НҮБХХ-ийн үйл ажиллагааны эдгээр гурван үндсэн салбар дахь гол ололт амжилтыг тайлагнан оруулав. Хавсралт 1-д тусгасан хяналт үнэлгээний матриц нь ТХҮАТ-нд тусгаж баталсан үр дүнгүүд болон шалгуур үзүүлэлт дээр тулгуурлан хэрэгжилтийн ахиц дэвшлийг тоймлон харуулсан. Дараагийн хэсэгт танилцуулах хөтөлбөрийн үр дүнгээс гадна Монгол улс олон улсын тавцанд өөрийн байр сууриа олоход НҮБХХ дэмжлэг үзүүлсээр ирсэн. Үүнд Монгол улс Рио+20 дээд хэмжээний уулзалтад бэлтгэх, Монгол улсад зохион байгуулагдсан "Азийн бүс нутагт улс төрийн тэгш оролцоог нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох нь", "Олборлох үйлдвэрлэл ба хүний хөгжил", 2013 онд "Дэлхийн байгаль орчны өдөр" зэрэг бүс нутгийн болон олон улсын бага хурлуудыг зохион байгуулах бэлтгэл ажил, мөн түүнчлэн 2015 оноос хойшхи хөгжлийн зорилтууд хэлэлцүүлгүүдийг хийх зэрэгт НҮБХХ дэмжлэг үзүүллээ.

Далайд гарцгүй орнуудын Олон улсын судалгааны төвийг албажуулан зохион байгуулах ажилд мөн дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд энэ нь НҮБХХ-ийн хөхиүлэн дэмждэг Өмнөд-Өмнөдийн санаачлагын хүрээнд хийгдэж байгаа ажлуудын нэг юм. Мөн түүнчлэн Монгол улсын Засгийн газрыг дэлхий дахины түршлага нөөц болон санал санаачлагуудтай зуучлан



холбох ажилд НҮБХХ идэвхитэй оролцдог. Үүнд Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (PAGE), олон улсын түршлага, мэргэжилтэнгүүдтэй холбох (жишээ нь Венад төвтэй НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон Дэлхийн Банкны хулгайлагдсан эд хөрөнгийг нөхөн олж авах санаачлагаар дамжуулан авлигатай тэмцэх) зэрэг гадны мэдээлэл түршлага, түүнчлэн Даян Дэлхийн Байгаль Орчны Сан, Уур Амьсгалын Өөрчлөлтэй Дасан Зохицох Сан зэрэг хөгжлийн төлөөх дэлхий нийтийн санхүүгийн эх үүсвэртэй холбож өгөх ажлыг НҮБХХ хийсээр ирсэн.

## **Ядуурлыг бууруулах болон МХЗ-уудыг хангах хүрээнд хэрэгжүүлж буй ажлын явц**

Үндэсний хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх нь засгийн газрын хариуцан хийх үндсэн ажлын нэг мөн. Бодлого боловсруулахдаа сайтар төлөвлөж оновчтой төсөв бүрдүүлж чадахгүй байгаа нь хөгжлийн үр дүн тааруу байхад нөлөөлөх хүчин зүйл болдог. МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2021) бол Монгол улсын урт хугацааны бодлогын бичиг баримт билээ.

Үндэсний хөгжлийн цогц бодлогын үнэлгээг НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр хийсэн бөгөөд уг үнэлгээний тайлангаар цогц бодлогын хэрэгжилтийн талаарх бэрхшээлтэй сул талуудыг гаргаж ирсэн байдаг. Шинэ засгийн газар байгуулагдаад Ерөнхий сайдын удирдлага дор Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулдаг бөгөөд энэ нь дөрвөн жилийн турш хэрэгжих засгийн газрын бодлого зорилтыг тодорхойлсон улс төрийн чухал бичиг баримт болно. Нийгэм-эдийн засгийн үндсэн чиглэл нь тухайн жилд хэрэгжүүлэх богино хугацааны үйл ажиллагааны хөтөлбөр бөгөөд тухайн жилийн төсөвтэй уягдаж засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн стратегийг түсгасан байдаг. Үндэсний хөгжлийн цогц бодлого, засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл, мөн түүнчлэн салбарын болон орон нутгийн бодлого, стратегийн хоорондын уялдаа холбоо сул байна. НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр Эдийн засгийн хөгжлийн яам хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж төв орон нутаг, төрийн бус байгууллага болон шинжлэх ухааны байгууллагуудыг хамруулан энэхүү хуулийг өргөн хүрээнд хэлэлцүүлээд байна. Энэ хууль болон түүнийг дагалдан гарах холбогдох удирдамжууд нь төлөвлөлтийн урт, дунд, богино хугацааны бодлогын бичиг баримтууд, мөн үндэсний болон орон нутгийн түвшиний бодлогын уялдаа холбоо бүхий төлөвлөлтийн тогтолцоог бий болгох эрх зүйн үндэс болно.

Энэ хуулийн төсөлд урт ба дунд хугацааны бодлого, стратегийн бичиг баримт бэлтгэх процедур журам, цаг хугацааны хүрээг тодорхойлон түсгэж өгсөн. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг (4 жил) боловсруулахад НҮБХХ дэмжлэг үзүүлсэн бөгөөд үүнд шаардлагатай үндэсний мэдээллийн санг байгуулсан. Түүнчлэн энэ мэдээллийн санг орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийн суурь мэдээлэл болох сумын хөгжлийн загварыг боловсруулахад ашигласан. Шинэ тулгарч гарч байгаа хөгжлийн асуудалд Монгол улсын бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын анхаарлыг татахын тулд хөгжлийн хэлэлцүүлгүүдийг НҮБХХ холбогдох төрийн

байгууллагуудтай хамтран зохион байгуулж ирлээ. Хөгжлийн хэлэлцүүлэг нь тодорхой сэдвүүдээрх хөгжлийн асуудлуудаар санал бодлоо хуваалцах, олон улсын сайн туршлагаас харилцан солилцох орон зайг бий болгож байна. 2012 оноос хойш үндэсний болон орон нутгийн засаг захиргаатай хамтран таван удаагийн үндэсний, хоёр удаа бүсийн хэмжээний хэлэлцүүлгийг зохион байгуулаад байна.

Монгол улсын засгийн газар 2 жил тутамд МХЗ-ын хэрэгжилтийн үндэсний тайлан гаргах замаар МХЗ-уудын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2013 онд МХЗ-ын хэрэгжилтийн үндэсний 5-р тайланг НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр бэлтгэсэн. 2013 оны ес дүгээр сард Монгол улсын ерөнхийлөгч Ц. Элбэгдорж НҮБ-ын Ерөнхий Ассамблейн МХЗ-уудын дээд хэмжээний уулзалт дээр 5-р тайлангаас өөрийнхөө илтгэлд тусган оруулж тайлагнасан болно.

Жижиг дунд үйлдвэрийн хөгжил болон хүн амын амьжиргааг сайжруулах чиглэлээр НҮБХХ тодорхой төслүүдийг хэрэгжүүлсэн. Энэ ажлын явцад гарсан нэг гол сургамж бол ядуурлыг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг боловсруулах нь нэн чухал гэдэг нь харагдлаа. Энэ чиглэлээр салбар хоорондын ажлын хэсэг саяхан байгуулагдсан бөгөөд НҮБХХ-өөс ажлын хэсэгтэй хамтран ажиллах зорилттой байна.

Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын судалгааны төвийг Монголд байгуулахад НҮБХХ дэмжлэг туслалцаа үзүүлсэн. Үүнд техникийн туслалцаа болон үйл ажиллагааг нь эрчимжүүлэх ажлууд багтсан. Одоо судалгааны төв нь хөгжлийн тулгамдаж буй асуудлуудаар далайд гарцгүй орнуудыг нэгтгэн, олон улсын түвшинд манлайлан удирдах боломж, байр суурийг Монгол улсад бий болгож байна. Энэ тал дээр засгийн газарт НҮБХХ дэмжлэг үзүүлсэн хэвээр байх болно.



## Ардчилсан засаглалын хүрээнд хэрэгжүүлж буй ажлын явц

Монгол улсад Улсын их хурлын болон орон нутгийн сонгуулийг 2012 онд, Ерөнхийлөгчийн сонгуулийг 2013 амжилттай, тайван замаар зохион байгууллаа. Улсын их хурлын ба орон нутгийн сонгуулийн шинэ тогтолцоо, сонгууль өгөх арга зүйн зөвлөмж зэрэг асуудлуудаар сонгогчдын дунд боловсрол, мэдээллийн кампанит ажлыг НҮБХХ-ийн туслалцаатайгаар зохион байгуулсан.

2012 оны сонгуулийн үр дүнд УИХ-д эзлэх эмэгтэйчүүдийн тоо 11 буюу 14.5% болж нэмэгдсэн. Хэдийгээр үндэсний түвшинд ийм амжилт гарсан боловч орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд эзлэх эмэгтэйчүүдийн тоо 2008 онд 30.9% байсан бол 2012 онд 27.3% болж буурсан. Монгол Улс 2015 он гэхэд парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг 30%-д хүргэх Мянганы хөгжлийн 3 дугаар зорилтыг хангах боломжгүй болох нь харагдаж байна. Сонгуулийн шинэчлэл хийх болон улс төрд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх бодлого дээр НҮБХХ тусламж дэмжлэг үзүүлсэн. Энэ тал дээр НҮБХХ үргэлжлүүлэн ажиллах болно.

Монгол Улс анх удаа иргэний боловсролын хөтөлбөрийг боловсруулан гаргасан бөгөөд бага, дунд ангийн иргэний боловсролын сурах бичгийг гаргах, багш нарыг сургах ажлыг НҮБ-ын дэмжлэгтэйгээр хийгээд байна.

Төсвийн шинэ хуулийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг 2013 оноос олгож эхэлсэн. Үүний үр дүнд улсын төсвийн нийт зарлагад орон нутгийн зарлагын эзлэх хувь 2011 онд 10.5% байсан бол 2013 онд 28.6% болж нэмэгджээ. Гэхдээ шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд нутгийн удирдлагын хувьд шингээж авах, хэрэгжүүлэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх сорилт тулгарч байгаа бөгөөд энэ чиглэлээр чадавхи бэхжүүлэх шаардлагатай байна. 2007-2011 онд хэрэгжүүлсэн “Орон нутгийн засаглалыг дэмжих” төслөөр дамжуулан аймаг бүрт өөрсдөө мэдэн зарцуулах, иргэдийн оролцоотойгоор төслийг сонгох төсвийн шинэ загварыг туршсан бөгөөд 2011 онд батлагдсан төсвийн хууль энэ загварыг Орон нутгийн хөгжлийн сан хэлбэрээр баталсан юм. Орон нутгийн хурлын зүгээс төсвийн гүйцэтгэлд хяналт тавих чадавхийг бэхжүүлэхэд НҮБХХ туслалцаа үзүүлэн дээрх шинэтгэлийн ажил, түүний хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлж байгаа болно.

Засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх асуудал одоогийн Засгийн газрын тэргүүлэх чиглэлийн нэг байгаа. Монгол улсын Ерөнхийлөгч “Шууд ардчилал, иргэний оролцоогоор дамжуулан төвлөрлийг сааруулах үндэсний дунд болон урт хугацааны бодлогын баримт бичиг” батлах тухай зарлигийг 2012 оны 9 дүгээр сард гаргасан. Төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны талаар гарч байгаа чухал санаачилга бол одоо боловсруулж байгаа Хуулийн тухай хууль бөгөөд хууль боловсруулах ажиллагаанд иргэдийг хэрхэн оролцуулах талаар олон улсын туршлагаас хуваалцах хүсэлтийг НҮБ-д гаргасан. Нийгмийн шинэ мэдээллийн хэрэгсэл болон бусад арга хэлбэрээр дамжуулан ардчилал, хүний эрх, жендэрийн тэгш байдал, нийгмийн шударга ёс гэсэн сэдвүүдээр залуучууд өөр хоорондоо хэлэлцүүлэг өрнүүлэх боломжийг хангах зорилгоор НҮБХХ залуучуудын сүлжээг дэмжин ажиллаж байна.

Монгол улс авилгатай тэмцэх алхамуудыг үргэлжлүүлэн хийж байна. Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн (АЭНҮБК) хэрэгжилтийн байдалд 2010-2011 онд үнэлгээ хийгдэж Венад төвтэй

НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй албанаас 2012 оны 10 сард Монгол Улсын хэрэгжилтийн байдлыг дүгнэсэн тайланг гаргасан. АЭНҮБК-ийн хэрэгжилтийн тайлангийн зөвлөмжид тусгагдсан авилгатай тэмцэх үндэсний бодлого стратеги боловсруулах ажилд НҮБХХ дэмжлэг үзүүлж байна. Дараагийн тайлан гарах хугацаа 2015 тохиох бөгөөд энд Конвенцийн II (Урьдчилан сэргийлэх) ба V (Алдагдсан хөрөнгийг эргүүлэн олж авах) бүлгүүд орох юм.

НҮБХХ-ийн “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн хүрээнд НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон StAR санаачлагын оролцоотой чадавхи бэхжүүлэх туслалцааг үзүүлж байна. Ашиг сонирхлын зөрчил, мэдээлэл олж авах зэрэг асуудлаарх эрхзүйн шинэтгэлийн ажил шинээр хэрэгжиж байгаа бөгөөд сургалт мэдээллийн аргаар дамжуулан хэрэгжилтийг сайжруулах шаардлага тавигдаж байна.

2010 оны Дэлхий нийтийн ээлжит хэлэлцүүлэг (хүний эрх) дээр хүний эрхийг хамгаалах ба дэмжих байдлаа сайжруулах тухай 129 зөвлөмжийг Монгол улс хүлээн авчээ. 2013 онд Женев хотноо төвтэй олон улсын ТББ болох UPR Info байгууллагаас энэ асуудлаарх дунд хугацааны үнэлгээ хэрэгжилтийн тайланг 2013 онд гаргасан. Монгол улсын хувьд 43 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 48 зөвлөмжийг хагас дутуу хэрэгжүүлж, 26 зөвлөмжийг гүйцэд хэрэгжүүлсэн байгааг энэ тайланд дурджээ. Аймаг бүрт сүлжээтэй Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс (МУХЭҮК)-д зориулсан төсвийг УИХ-аас саяхан батлаад байна. Орон нутгийн түвшинд байгаа одоогийн комиссыг өргөтгөх явдал нь 2011 оны 8-р сард зохион байгуулагдсан хүний эрхийн төлөө байгууллагууд, НҮБХХ болон хүний эрхийн дээд комиссарын газрын Ази Номхон далайн орнуудын хэлэлцүүлгийн тусламжтайгаар явуулсан чадамжийн үнэлгээнээс гарсан гол зөвлөмж юм. Хүний Эрхийн Комиссын үйл ажиллагааг өргөтгөх ажлын хүрээнд Улаанбаатар хотын гадна амьдардаг хүмүүст комиссын үйлчилгээг ялангуяа комиссын гомдол барагдуулах үйлчилгээг авах боломжтой болгоно. Шинээр гарч ирж буй хүний эрхийн асуудал тухайлбал хүний эрхэд уул уурхайн салбарын нөлөөлөл, бэлгийн цөөнх, шашны сургуульд явдаг хүүхдүүд болон, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүрч ажиллах зэрэг асуудлыг МУХЭҮК 2012 оны Монгол улсын хүний эрх ба эрх чөлөөний тайланд онцлон тэмдэглэжээ.

Нэгдсэн үндэсний хүний эрхийн байгууллагуудын өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийн явцад зориулан энэ тайланд тусгай хэсгийг гаргасан байна. Анхны удаа, уг тайлангийн зөвлөмжүүдийг баталж, ерөнхий сайдад зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хүсэлт гаргасан байнгын хорооны тогтоол батлагджээ. *(Хууль зүйн байнгын хорооны шийдвэр 2013 оны долоон сарын 3, #13)*. Үүний үндсэн дээр МУХЭҮК-ын баримтад тулгуурлан гаргасан мэдээлэл тайланг НҮБХХ дэмжин ажилласан юм.

Төлбөрийн чадваргүй яллагдагчдын эрх зүйн туслалцааны тухай хууль 2013 оны долдугаар сард батлагдсан. Одоог хүртэл бодитой хэрэгжихгүй байсан иргэдийн хууль эрх зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулахад 1992 оны Үндсэн хуулийн заалт 16.14-ын талаар авч үзэж байгаа нь олзуурхуштай үйл явц юм. Хууль эрх зүйн хураамж төлж чадахгүй байгаа хүмүүст хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, хамгаалал үзүүлдэг үндэсний эрх зүйн туслалцааны тогтолцоог бий болгоход уг хуулийн зорилго оршино. 2007-2011 онд Хууль зүйн яамтай хамтран хэрэгжүүлсэн “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх” төслөөр дамжуулан эрх зүйн туслалцааны төвүүдийг байгуулсан бөгөөд энэ санаачлага түршлага дээр тулгуурлан тус сайн түршлагыг өргөжүүлж эрх зүйн туслалцааны шинэ тогтолцооны загварыг гаргасан. Энэ тогтолцоо нь одоо

ажиллаж байгаа Эрх зүйн туслалцааны төвүүд дээр тулгуурлан Хууль зүйн яамны харьяа төв байгууллага болон өргөжих бөгөөд эрхзүйн туслалцааны төвүүдэд зааварчилгаа өгч, хяналт-шинжилгээ явуулдаг 72 өмгөөлөгч ажиллахаар зохицуулагдсан байна. Төслийн хүрээнд Эрх зүйн туслалцааны төвүүдийн чадавхийг бэхжүүлэх ажилтай зэрэгцүүлэн санхүүгийн тусламжийг аажим бууруулах замаар бие даалгах бодлогыг анхнаасаа сайтар бодож боловсруулан хэрэгжүүлсэн нь одоогийн энэ амжилтанд хүрч НҮБХХ хувь нэмрээ оруулах боломжийг олгосон.

2012 он гэхэд Монголын Засгийн газар эрх зүйн тусламжийн төвүүдийг бүрэн хариуцан ажиллах болсон. Эдгээр төвүүдэд хуваарилсан Засгийн газрын төсөв 2008 онд 5 сая байснаа 2013 он гэхэд 1,48 тэр бум төгрөг болж анхны түвшнээс 300 дахин өсчээ. Энэ нь нийгмийн хамгийн эмзэг хэсэгт зориулсан хууль эрх зүйн тогтвортой хамгаалалт Монгол улсад бий болсныг илтгэж байна. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аар хэлэлцэж байгаа нь эрх зүйн ба бодлогын шинэ орчинд хэрэгжүүлэх шинэтгэлийн хувилбаруудын талаар бодлогын хэлэлцүүлэг хийх томоохон боломжийг нээж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс саяхан гаргасан “Том төрөөс ухаалаг төр рүү” санаачилга онцлох үйл явдал болсны зэрэгцээ улс төрийн хүрээнд өргөн дэмжлэгийг хүлээгээд байна. Ухаалаг төрийн шинж чанарыг “оновчтой хэмжээтэй, хүнд сурталгүй, хуулийн засаглалыг мөрдлөг болгодог, иргэдэд үйлчилдэг” хэмээн тодорхойлжээ. Тусламжийн хөтөлбөрийн үлдсэн хугацаанд нь эдгээр асуудлын хүрээнд НҮБХХ анхааран ажиллана.

## **Байгаль орчин ба тогтвортой хөгжлийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлын явц**

Тогтвортой хөгжлийг хангахад ногоон хөгжлийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч Монгол улсын шинээр сонгогдсон засгийн газар 2020 он хүртэлх үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ногоон хөгжлийн бодлогыг тусгасан. НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр Монгол улсын Засгийн газар үндэсний ногоон хөгжлийн стратегийг боловсруулж дуусаад 2013 онд УИХ-аар батлуулахаар өргөн барьсан. Монгол улс дэлхийн байгаль орчны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг амжилттай зохион байгуулсан бөгөөд энэ үеэр ногоон эдийн засгийн төлөөх түншлэл (PAGE)-д нэгдэн орсон анхны улс болжээ.

Монгол Улсын Улсын Их Хурал 2012 оны 5-р сард байгаль орчны багц хуулийг баталсан нь 1990 оны үеэс хойш батлагдан мөрдөгдөж байсан эрх зүйн тогтолцооны анхны том эрх зүйн шинэчлэл болсон. Байгаль орчны эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 33 хуулиас 18 хуулийг 8 болгон нэгтгэж, шинээр 2 хууль боловсруулсан нь хуулийн давхардал, хийдэл, орхигдлыг арилгахад чухал хувь нэмэр оруулсан болно. Шинээр батлагдсан хуулийн багцанд зарчмын олон шинэлэг зүйл орсон ба бохирдуулагч төлөх зарчим, нутгийн иргэд байгаль газар орон нутгаа хамгаалах, байгалийн нөөцийн менежмент хийхэд нутгийн иргэдийн оролцоог хангах асуудлууд тусгагдсан. Үүнээс гадна байгаль орчны менежментийн арга хэрэгсэлүүд болох байгаль орчны аудит болон байгаль орчны стратегийн үнэлгээг тус тус хуульчилсан. Шинэчилсэн хуулийн багцыг хэрэгжүүлэх зорилгоор дагалдах 100 гаруй дүрэм, журам болон аргачлалыг боловсруулсан. Нэмэлт хэд хэдэн хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтүүдийг 2013 онд үргэлжлүүлэн хийсэн юм.

НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр байгаль орчны аудитыг хуульчилж, холбогдох журам, аргачлалыг боловсруулан батлуулж, аж ахуйн нэгж, байгаль орчны аудиторруудад гэрчилгээ олгох сургалтын эхлэлийг амжилттай тавьсан болно.

Байгаль орчны асуудлаар шийдвэр гаргах явцад ард иргэд болон иргэний нийгэм оролцох боломж улам бүр нэмэгдсээр байна. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам “Ногоон хөгжлийн түншлэл” үндэсний чуулганыг 2013 онд зохион байгуулж, төрийн зарим ажил, үүргийг хувийн хэвшлээр хэрэгжүүлэх боломжийг тусгасан “Төр ба хувийн хэвшлийн түншлэл”-ийн тунхаг бичгийг баталсан болно.

Мөн байгаль орчны асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох, зөрчигдсөн эрхийг сэргээх тухай Аархусын Конвенцийн талаар Байгаль орчин, ногоон хөгжлийн яам 2013 онд Улсын Их Хуралд танилцуулга хийсэн болно. НҮБХХ байгаль орчны чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын хэрэгцээ шаардлага чадавхийн үнэлгээ хийх ажилд НҮБХХ дэмжлэг үзүүлсэн.

Дэд салбарын түвшинд дан ганц хамгаалалтанд анхаарлаа хэт чиглүүлэхээс илүүтэйгээр ойн нөөцийг тогтвортой бөгөөд хог хаягдалгүй ашиглах боломжийг бий болгох зорилгоор ойн талаарх төрийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулсан.

Саяхан Засгийн газар 2020 он хүртэл хэрэгжих ой цэвэрлэх хоёр үе шаттай хөтөлбөрийг баталсан. НҮБ-REDD хөтөлбөрөөр дамжуулан 2014 онд олон зорилтот ойн нөөцийн бүртгэлийн системийг нэвтрүүлсэн. Амьдрах орчин нь хил дамнан оршдог нэн ховордсон төрөл зүйлийг хамгаалахад чухал ач холбогдол бүхий хил дамнасан түсгай хамгаалалттай нутгийг (нийт 680.000га) ОХУ-ын хилийн дагуу 2013 онд байгуулсан.

2013 оны 12 дугаар сарын байдлаар нийт нутаг дэвсгэрийн 17.4%-г түсгай хамгаалалтад авсан байна. Байгалийн нөөцийн менежментийг ТББ-аар хийлгэх, орон нутгийн засаг захиргааны төсөвт энэ талаар анх удаа тусгах албан ёсны хэлэлцээг амжилттай явуулахад НҮБХХ туслалцаа үзүүлсэн.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам ашигт малтмалын ашиглалтын лицензийн олголтыг 2010 оноос зогсоосны зэрэгцээ уул уурхайн ашиглалт, олборлолт явуулж болохгүй экологийн өндөр ач холбогдолтой, гадаад нөлөөнд өртөмтгий эмзэг газруудыг тогтоохоор ажиллаж байна. Хэд хэдэн экобүсийг хамарсан судалгааны ажлуудыг хийгээд байна.

2012 онд зохион байгуулагдсан Тогвортой хөгжлийн талаарх Рио+20 НҮБ-ын Бага хуралд Монгол улс амжилттай оролцсон ба бэлтгэл ажлын хүрээнд Монгол улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад үнэлэлт дүгнэлт өгсөн болно. Уг уулзалтын хажуугаар төлөөлөгчид улс орны тогтвортой хөгжлийн ололттой тал болон 2020 он гэхэд нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн 20%-ийг дахин сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл болгох талаар илтгэсэн бага хурлын дэргэдэх нэмэлт хуралдааныг Монгол улс зохион байгуулав.

Тогтвортой хөгжилд хүрэхийн тулд ногоон өсөлт чухал ач холбогдолтой болох тул энэ талаар өргөн хүрээний судалгаа хийж ногоон хөгжлийн төлөвлөгөөнд ногоон өсөлтийн бодлогыг нэвтрүүлэхээр тусгасан болно. Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах чиглэлээр олон

улсын байгууллагууд болон хоёр улсын хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан хэд хэдэн санаачлагад нэгдэн орж, Япон улсын хамтарсан кредит олгох механизмыг хэрэгжүүлэх болон Даян дэлхийн ногоон өсөлтийн хүрээлэнтэй хамтарч ажиллах гэрээг байгуулсан болно.

Ногоон хөгжлийн бодлогын хэд хэдэн арга хэмжээнүүдийг салбар хоорондын болон яамд хоорондын хамтын ажиллагааны хүрээнд нэвтрүүлсэн билээ. Үүнд үйлдвэрийн зориулалтаар ашиглаж буй усны үнийг нэмэх, залуучуудад зориулсан албан ёсны экологийн боловсролын хөтөлбөрийг боловсруулах санаачлага, эрчим хүч, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай үйлдвэрийн техник төхөөрөмж, зарим нэг гэр ахуйн болон модон эдлэлийг худалдан борлуулсан тохиолдолд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлж байхаар шийдвэрлэсэн бөгөөд түүнчлэн эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламжинд зориулсан санхүүгийн дэмжлэгийн тогтолцоог эхлүүлэх мөн эрчим хүчний үр ашигийн шинэ хуулийг боловсруулах тал дээр ажилласан юм.

Ерөнхийд нь дүгнэхэд, үндсэн дүрэм журмыг боловсруулдаг гол яамдуудын нэг гэдэг үүднээс Байгаль орчин, ногоон хөгжлийн яам өндөр бүтээмжтэй ажиллаж байна. Энэ чиглэлээр Байгаль орчин ногоон хөгжлийн яам болон Монгол улсад дэмжлэг үзүүлэх гол түнш нь НҮБХХ хэвээр байна.

Нийслэл хотод гэр хорооллыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, өвлийн улиралд гамшгийн хэмжээнд хүрсэн агаарын бохирдолыг бууруулах, ахуй амьдралын нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор Монгол улсын Засгийн газраас захын хорооллын бага болон дунд орлоготой өрхүүдэд орон сууцны урт хугацааны бага хүүтэй (жилд 6% ) зээлийг олгож эхэлсэн.

Монгол улсын Засгийн газар хүн амын хамгийн эмзэг давхаргын иргэд оршин суудаг гэр хорооллын сэргээн босгох ажлын хэрэгжилтийг хурдавчлуулах шийдвэр гаргасан бөгөөд нийслэлийн мастер төлөвлөгөөний хүрээнд гэр хорооллыг орон сууцны барилгаар солих нэгдсэн ажил, түүнчлэн гэр хорооллын оршин суугчид хувийн эзэмшлийн газраа орчин үеийн орон сууц болгон зарах боломжыг олгосон ажлууд хийгдлээ.

2013 онд Монгол улсын засгийн газар иргэддээ зах зээлийн ханшнаас хоёр дахин бага орон сууцны 8%-ийн зээлийг авах эрхийг нээж өгсөн. Орон сууцны хангамж тогтвортой байх, санхүүгийн эрсдэлийг багасгах зорилгоор барилгын материал үйлдвэрлэгчдэд болон барилгын компаниудад засгийн газраас татаас олгосон.

2012-2013 онд ойролцоогоор 148 000 гэр хорооллын оршин суугчдад түүхий нүүрс бага хэрэглэдэг түлшний хэмнэлттэй зуухыг БОНХЯ-ны дэргэдэх "Цэвэр агаар сан"-гаас татаастай (90 %) олгосон. Мөн НҮБХХ барилгын норм, дүрэм, стандартыг боловсруулах ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн.







Хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор, шинээр баригдах нийтийн орон сууц, барилгын ажлыг эрчим хүчний хэмнэлттэй барилгын технологүүдыг ашиглан гүйцэтгэх ажлууд тусгагдсан сумын хөтөлбөрийг 3 суманд амжилттай эхлүүлэв. Энэ ажил дээр тулгуурлан 2014 онд тус хөтөлбөрт нэмж 16 суурин газруудыг хамруулахаар төлөвлөөд байна. Засгийн газраас баталсан дахин ашиглаж болдог төвлөрсөн ус хангамж, бохир ус цэвэршүүлэх системийн моно-терлийн загваруудыг хоёр сумын төвд байгуулахад НҮБХХ дэмжлэг үзүүлсэн.

НҮБХХ-ийн тусламжтай хэрэгжүүлсэн ус хангамж болон ариутган цэвэрлэх үйлчилгээний хүртээмжийг улсын хэмжээнд нэмэгдүүлэх аргачлалыг боловсруулж энэ нь улсын статистикийн албаны мэдээлэл цуглуулах нэгдсэн сангийн тогтолцоонд нэгтгэгдээд байна. Мянганы Хөгжлийн Зорилт (МХЗ)-ын хэрэгжилтийн үндэсний 5 дахь илтгэлд хэдийгээр зохих арга хэмжээг авч байгаа боловч 7 дугаар зорилго буюу Байгаль орчны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа хэд хэдэн үзүүлэлтээр удаашралтай байгааг тэмдэглэсэн болно.

## **Хөндлөнгийн үнэлгээний тайлан ба аудитын зөвлөмжүүд**

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн баримт, бодит мэдээлэл дээр тулгуурлан явагдах зарчмыг хангах үүднээс НҮБХХ явуулж буй үйл ажиллагаандаа хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлдэг. Эдгээр үнэлгээ нь НҮБХХ-ийн төсөл хөтөлбөрүүдийн ач холбогдол, үр ашигтай байдал болон бүтээмжийг үнэлж дүгнэдэг.

Ерөнхийдөө, бие даасан үнэлгээний тайлангуудад дараах гол амжилт бүтээлийг цохон тэмдэглэсэн байна. НҮБХХ нь:

-  Үндэсний хууль эрх зүйн чанарыг сайжруулахад сайнаар нөлөөлсөн,
-  Бодлогын бичиг баримт боловсруулахад үр нөлөөтэй байж чадсан,
-  Улс төрийн дэмжлэгийг бий болгож олон янзын оролцогч талуудыг нэгтгэсэн,
-  Шинэ тулгарч гарч ирсэн хөгжлийн сэдвүүдийг хөндөж, тэдгээрт холбогдох асуудлуудыг шийдвэрлэх алхамуудыг хийсэн,
-  Олон нийтийн оролцооны аргыг сайн ашигласан,
-  Зохион байгуулалт сайтай ба үян хатан арга барилыг хөтөлбөртөө хэрэгжүүлсэн зэргийг дурьдсан байна.

### **Үнэлгээний тайлангаас:**

Газрын тогтвортой менежментийн төсөл нь цөлжилттэй тэмцэх, байгаль орчинг нөхөн сэргээх ажлын хүрээнд шинэ хуулиудыг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Үнэлгээний тайланд уг хууль нь “газрын доройтлыг нөхөн сэргээхэд чиглэсэн томоохон алхам бөгөөд орон нутгийн бэлчээрийг хамгаалахад ашиглах хүчирхэг хэрэгсэл болжээ” гэж дүгнэсэн байна.

НҮБХХ-аас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд эрчим хүчний хэрэглээг багасгаж нийт 9,345 тонн CO<sub>2</sub> тэнцэх хүлэмжийн хийн ялгаралтыг Улаанбаатар хотод бууруулсан. 186,899 тонн (шууд ялгаралтын бууралт) хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад НҮБХХ хувь нэмэр оруулсан гэж тооцсон байна. НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр олон улсын эрчим хүчний үр ашгийн шаардлагад нийцсэн барилгын норм, стандартыг боловсруулах, шинэчлэх ажлын үр дүнд энэхүү амжилтанд хүрсэн. Энэ нь орон сууцны барилгын салбарын ирээдүйн бүтээн байгуулалтад цаашид сайн нөлөө үзүүлсэн хэвээр байх төлөвтэй байна.

Цэвэр нүүдэлчин, малчин иргэнээс олон салбарын аж ахуйн нэгжийн хэлбэрлүү шилжих суурь өөрчлөлтүүдийг хийснээр малчин иргэдэд тулгардаг байгалийн гамшигийн эрсдлийг бууруулах, амьжиргаагаа дээшлүүлэхэд нь НҮБХХ өндөр хувь нэмэр оруулжээ. Энд чиглэгдсэн ажлын хүрээнд малчид бараа бүтээгдэхүүнүүдээ борлуулах илүү сайн нөхцөлөөр хангагдаж ажлын байр шинээр бий

болж, төслийн үр шимийг хүртэгчид борлуулалтын улам өргөн сүлжээтэй болсон нь тэдний ашиг орлого нэмэгдэхэд ихээхэн тус нэмэр болжээ. Нийт 1500 малчидыг мэргэжлийн сургалтанд хамруулсан байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь төсөл зохион байгуулалт сайтай, олон нийтэд сайнаар үнэлэгдсэн, уян хатан менежменттэй, мөн төслийн баримт бичигт дурьдсан үр дүнд хүрсэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ туршлага нь үндэсний болон бүс нутгийн хэмжээнд онцлох явдал юм гэж үнэлгээний тайланд дүгнэжээ.

Тусгай хамгаалалттай газрыг хадгалан авч үлдэхэд чиглэсэн НҮБХХ-ийн үйл ажиллагаа нь улс төрийн дэмжлэг ихээр хүлээж чаджээ. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудлаарх Үндэсний Чуулган зохион байгуулах ажлыг тогтмолжуулж, Хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг баталгаажуулах асуудлаар агентлаг хоорондын ажлын хэсэг байгуулагдсан. Эдгээр ололт амжилт нь хамгаалалттай газар нутгийн талаар баримтлах бодлого, хууль эрхзүйн орчинг бэхжүүлэхэд олон оролцогч талуудыг идэвхижүүлж чадсан нь анхаарал татаж байна.

Түүнчлэн иргэдийн оролцоо, байгалийн нөөцийг тогтвортой ашиглах зэрэгт онцгойлон анхаарч, байгаль орчныг хамгаалан хадгалах ажил болон иргэдийн амьжиргаа дээшлүүлэх арга хэмжээ хоёр харилцан эерэг нөлөөтэй байж болох талаар таниулан ойлгуулах ажил хийгдсэн. Үүний үр дүнд төслөөс сонгон хэрэгжүүлж буй газруудын ард иргэд болон орон нутгийн засаг захиргааны хандлага эрс өөрчлөгджээ. Орон нутгийн иргэдийг татан оролцуулах энэ аргыг үндэсний хэмжээнд өөр газруудад өргөн нэвтрүүлэх боломжтой юм.

Төслүүдийн үнэлгээний тайлангуудаас авах хэд хэдэн сургамжууд бий. Үүнд:

- 🚦 Төлөвлөлт сайн байх хэрэгцээ:
  - НҮБ-ын хамтарсан хөтөлбөрүүдийн төлөвлөлт ба хэрэгжилтийг илүү нэгдсэн болгох,
  - Үр ашиг хүртэгсэд буюу зорилтот бүлгийг илүү сайн тодорхойлох,
  - Асуудлыг өргөн хүрээнд харж, санхүүгийн талаас нь тооцоолон үзэх замаар сайн туршлагыг өргөжүүлэхэд анхаарал хандуулах,
  - Төсөл дууссаны дараа ч үр дүн нь хөгжилд эерэгээр нөлөөлж байх тогтвортой байдлыг баталгаажуулах зорилгоор холбогдох арга хэмжээг төслийн бичиг баримтад түлхүү суулгаж өгөх;
- 🚦 Үндэсний хэмжээнд үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах. Үндэсний бодлого, хууль эрхзүйн зүйл заалтуудыг төсвийн хуваарилалттай холбох буюу аливаа үйл ажиллагааг төсөвтэй уялдуулах ажлыг эрчимжүүлэх;
- 🚦 Хяналт-шинжилгээ, үнэлгээг илүү сайн явуулж, энэ ажлыг төслийн жилийн ажлын төлөвлөгөө болон төсөвт суулгах хэрэгтэй гэсэн дүгнэлтүүд гарчээ.



### **Үнэлгээний тайлангаас:**

2010-2013 онд авч хэрэгжүүлсэн НҮБ-ын ус, ариун цэврийн хангамжийг сайжруулах хамтарсан хөтөлбөрийн үнэлгээ нь НҮБ-ын системийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг сайжруулах хэрэгцээ байгааг харуулж байна. Зарим нэг байгууллагуудын хэрэгжүүлэх арга барил давуу талтай байж болох ч зарим үйл ажиллагааг давхардалтайгаар зэрэгцэн явуулж байсан нь хамтарсан хөтөлбөрийн сул тал болж үүнээс улбаалан гарах сөрөг үр дүн нь нийт үзүүлэх үр ашигтай байдлыг бууруулсан байна гэж дүгнэжээ. Ус, ариун цэврийн дэд бүтцийг барих барилгын ажлын худалдан авалт, орон нутагт очиж ажилтай нь танилцах, хамтын хяналт тавих зэргээр хамтарсан хөтөлбөрийн үр дүнг сайжруулах хэрэгтэй байгааг онцлон тэмдэглэсэн. Үүнээс гадна, тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хуваарилсан нөөц хангалтгүй байгааг дурджээ. Санхүүгийн эх үүсвэр хангалтгүй байснаас шалтгаалан, Барилгын эрчим хүч хэмнэлтийн төслөөс (БЕЕР) томоохон барилгын компаниудтай хамтран ажиллаж чадаагүй нь төслийн хүрч болох үр дүнг бууруулсан гэж тэмдэглэжээ.

Жил тутам явагддаг санхүүгийн аудитын явцад гарсан тулгамдаж буй асуудлууд болон зөвлөмжүүдэд НҮБХХ дүн шинжилгээ хийдэг. 2011 оны аудитын үр дүнтэй холбогдуулан НҮБХХ-өөс үндэсний хэрэгжилтийн гарын авлагадаа өөрчлөлт оруулах, төслийн санхүүгийн зохицуулалт дээр нэмэлт удирдамж гаргаж өгөхийг шалгалтын алба санал болгосон. Шалгалтийн холбогдох зөвлөмжүүдийг биелүүлэх хүрээнд, төсөл хэрэгжүүлэх дүрэм журмын талаар НҮБХХ удирдамж гаргасан. Мөн НҮБХХ-ын гишүүн орнуудад мөрдөгдөж байгаа үндэсний хэрэгжилтийн шинэ гарын авлагыг даган мөрдөж байна.

### **Хэрэгжилтийн явц**

НҮБХХ-ийн шинээр гаргасан үндэсний хэрэгжилтийн журам, удирдамжийг сүүлийн хоёр жилийн хугацаанд шинээр батлагдсан бүх төслүүд дээр хэрэгжүүлж байна. НҮБХХ-ийн дэлхий нийтийн бодлоготой нийцүүлж үндэсний хэрэгжилтийн аргыг ашиглах хүрээнд Монгол улсад мөрдөгддөг үндэсний дүрэм журамыг ашиглах тал дээр НҮБХХ анхаарлаа түлхүү хандуулж байна.

Энэ шинэ журмын дагуу НҮБХХ төслийн бичиг баримт болон жилийн ажлын төлөвлөгөөнд хариуцагч талуудыг тодорхой зааж өгөх, үндэсний байгууллагуудад хүчин төгөлдөр үйлчилдэг дүрэм журмуудыг мөрдлөг болгох шаардлагатай болж байгаа бөгөөд өмнө нь ашиглаж байсан хэрэгжилтийн холимог аргыг огт хэрэглэхгүй болсон билээ.

Гэсэн хэдий ч, НҮБХХ-ийн дэмжлэгтэй хэрэгжих төслүүдэд үндэсний дүрэм журмыг мөрдлөг болгоход зарим нэг саад бэрхшээл гарч байгаа бөгөөд тухайлбал банкинд төслийн дансыг бий болгох, НӨАТ-ын хураамжийг хэрхэн зохион байгуулах, түнш байгууллагын төлбөр тооцоо саатах, үндэсний хууль тогтоомж, дүрэм, журмуудын хоорондын зөрчилтэй байдал, зах зээлийн нөхцөлд нийцэхгүй томилолтын мөнгө бодогдох зэрэг асуудал гарч байна. Үүнээс гадна, төсөл хэрэгжүүлэгч зарим нэг түнш байгууллагуудаас үндэсний дүрэм журмыг дагаж эхлэхэд шилжилтийн үе хэрэгтэй байгаа талаар саналаа илэрхийлж байна.

Монгол дахь НҮБХХ дээр дурьдсан бэршээл асуудлуудыг аль болох зохистой байдлаар шийдвэрлэхийн тулд Сангийн Яам болон хэрэгжүүлэгч түнш байгууллагуудтай тухайн асуудлыг

нарийвчлан хэлэлцэж байгаа бөгөөд энэ ажилдаа төслийн хэрэгжилтэд оролцох үндэсний албан байгууллагуудыг идэвхитэй хамрагдахыг уриалж байна.

Одоогоор Монгол дахь НҮБ-ын системийн байгууллагуудаар хэрэгжүүлж буй НҮБХХ-ийн төсөл байхгүй, харин ТББ-ын хэрэгжүүлж буй төслүүд байна. Монгол дахь НҮБХХ ТББ-ын хэрэгжүүлж буй төслүүдийг хянаж, цаашдын хэрэгжилтийн явц дахь хяналтын системийг сайжруулах тал дээр анхааран ажиллана.

## Дүгнэлт ба зөвлөмж

Тайлан, үнэлгээний үр дүнд үндэслэн, авч явуулах үндсэн арга хэмжээ, өөрчлөлтийн саналыг ТХУАТ-ын хэрэгжилтэнд хийж байгаа энэ хэлэлцүүлгийн явцад хамтран зөвлөлдсөний үндсэн дээр шийдэх юм. Эдгээр нь стратегийн ач холбогдолтой хүчин зүйлс (*боломж, үр нөлөө, харьцангуй давуу тал, хамтын ажиллагаа гэх мэт*), нөөцийн хүчин зүйлс (*Монгол дахь НҮБХХ-ийн хүчин чадал, бэлэн санхүүжилт, дайчлах боломжтой нөөц гэх мэт*) болон эрсдэлт хүчин зүйлс (*техникийн, чадавхийн, улс төрийн гэх мэт*) зэргээс салбарлан гарч болно. Гол арга хэмжээ болон өөрчлөлтийн саналыг доор тусгалаав:

Асуудал	Санал болгож буй арга хэмжээ	Хариуцагч	Хугацаа
<b>Тусламжийн хөтөлбөрийн үйл ажиллагааны зохион байгуулалт</b>	Тусламжийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх албан ёсны уулзалтыг наад зах нь жилд нэг удаа зохион байгуулдаг болох	НҮБХХ, ГХЯ, ЭЗХЯ	2014 оны 1-р улирал
<b>Сайн туршлагыг өргөжүүлэн дэлгэрүүлэх хөтөлбөр</b>	Хэрэгжиж дууссан цаашид өргөжүүлэх боломжтой сайн туршлага боломжуудыг нягталж үзэх, дүн шинжилгээ хийх	НҮБХХ, Хэрэгжүүлэгч байгууллагууд	2014 он
<b>Хөтөлбөрийн агуулгын өөрчлөлт</b>	Үр дүнгүүдийн матриц дээр гарсан өөрчлөлтүүд	НҮБХХ, ГХЯ, Хэрэгжүүлэгч байгууллагууд	2014 оны 1-р улирал
<b>Шинэ салбар болон асуудлыг танилцуулах</b>	Хилийн менежмент, хотжилт, олборлох үйлдвэр болон хүний хөгжилд дэмжлэг үзүүлэх, судалгаан дээр үндэслэн хөтөлбөрийн шинэ санал боловсруулах (оновчтой нөөц бололцоон дээр тулгуурлах)	НҮБХХ, ГХЯ, Хэрэгжүүлэгч Байгууллагууд	2014 он
<b>Жендэрийн асуудлыг бодлогод тусгах (Жич: Энэ нь бас үр дүнгийн матрицад орсон)</b>	Үндэсний төсөв төлөвлөлтөнд жендэрийн асуудлыг тусган дүн шинжилгээ хийх, жендэрийн мэдээллийг ангилах хэрэгтэй. НҮБХХ-ийн байгаль орчны баримт бичгийг Жендэрийн талаас нь дахин авч үзэх	НҮБХХ, ЖЕХ	2014 оны 3-4-р улирал
<b>Хяналт үнэлгээ</b>	ТХУАТ ба үнэлгээний матриц шинэчлэгдсэн байх	НҮБХХ	

<b>Асуудал</b>	<b>Санал болгож буй арга хэмжээ</b>	<b>Хариуцагч</b>	<b>Хугацаа</b>
	Төслүүдэд хяналт ба үнэлгээний талаарх сургалт хийх	НҮБХХ, ЭЗХЯ, Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Q2 2014 2014 оны 2-р улирал
	Төслийн хяналт ба үнэлгээний хүрээ, матрицийг үнэлэх, сайжруулах	НҮБХХ	2014
<b>Харилцаа холбоо, сурталчилгаа</b>	Төсөл тус бүр энэ тал дээр нэг түвшнээр ахисан байх	Хэрэгжүүлэгч байгууллагууд НҮБХХ	2014
	Монгол хэл дээрх мэдээллийг илүү түлхүү бэлдэх	НҮБХХ, Хэрэгжүүлэгч байгууллагууд	2014
<b>Төслийн шууд өртөг зардал тооцох</b>	Төслийн шууд зардлын тооцоог хийх	НҮБХХ ба Хэрэгжүүлэгч Байгууллагууд	2014 оны 1-р улирал
	Үйлчилгээний үнийн жагсаалтыг боловсруулах	НҮБХХ	
<b>Санхүүгийн асуудлуудыг шийдвэрлэх</b>	Монгол дахь НҮБХХ нь санхүүгийн хувьд тогтвортой байж үр дүнтэй ажиллах зорилгын хүрээнд байгууллагын бүтцэд өөрчлөлт хийх	НҮБХХ	2014 оны 1-2-р улирал
	Гол хандивлагч нартай хамтарч хөрөнгө босгох ажил	НҮБХХ, ЭЗХЯ, ГХЯ, Хэрэгжүүлэгч Байгууллагууд	2014
<b>Үндэсний хэрэгжилт</b>	Засгийн газрын тогтолцоог илүү ашиглах, ерөнхий чиглэл-тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх ажлийн хэсгийг томилох	НҮБХХ, СЯ, ЭЗХЯ, ГХЯ	2014 оны 1-р улирал
	Төсөл хэрэгжүүлэх түнш байгууллагуудын чадавхийн үнэлгээ хийх	НҮБХХ, Хэрэгжүүлэгч Байгуулгууд	2014 оны 1-р улирал
<b>Засгийн газрын зардал хуваах зарчим</b>	НҮБХХ-ийн төслүүдэд Засгийн газраас зардал хуваах боломжийг судлах, холбогдох журмыг боловсронгуй болгох	НҮБХХ, СЯ, Эдийн засгийн хөгжлийн яам, ГХЯ, Хэрэгжүүлэгч Байгууллагууд	2014 оны 2-р улирал

## Хавсралт 1. Үр дүн болон нөөцийн хяналтын мартиц 2012-2016

НҮБХТХ-ийн үр дүн: 1		Эдийн засгийн хөгжлийн үр шимийг тэгш хүртээх замаар ядуурлыг бууруулах	
Шалгуур үзүүлэлт:	Ядуурлын түвшинд хувь буурсан	Одоогийн түвшин:	Ядуурлын түвшин: 27.4%
	Gini коэффициентийн өөрчлөлтийн хувь		Gini коэффициент: 0.33
Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Суурь үзүүлэлт	Хүрэх түвшин	Одоогийн түвшин
<p>Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ) болон Мянганы Хөгжлийн Зорилтын (МХЗ)-ын уялдаа, хэрэгжилтыг эрчимжүүлэх төлөвлөгөө, хяналт үнэлгээ % шинжилгээний төлөвлөгөө, % ядуурлын түвшин</p> <p><b>Санал болгож буй өөрчлөлт:</b> Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль боловсруулан батлуулахад гарч буй ахиц</p>	<p>ҮХЦБ-ыг МХЗ-той уялдуулах шаардлагатай; Бодлого, төлөвлөлтийн уялдаа сул</p> <p><b>Санал болгож буй өөрчлөлт:</b> Бодлогын уялдаа холбоо муу байгаа бөгөөд хөгжлийн бодлого болон төлөвлөлтийг зохицуулдаг ямар нэгэн дорвитой хууль байдаггүй</p>	<p>ҮХЦБ-ын хэрэгжилт сайжирна.</p> <p><b>Санал болгож буй өөрчлөлт:</b> Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль батлах, хэрэгжүүлэх</p>	<p>Уг хууль 2014 онд батлагдах</p>
Тэгш бус байдал болон ядуурлыг бууруулах арга хэмжээг тусгасан Ядуурлыг бууруулах	ЯБҮХ боловсруулаагүй	Хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн хамгааллын асуудлыг тусгасан ЯБҮХ	2014-2015 онд боловсруулах

үндэсний хөтөлбөр (ЯБҮХ)			
Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын (ДГХБО) Олон улсын Судалгааны Төв (ОУСТ)-ийн чадавхи; ДГХБО-ын асуудлаар хийгдсэн судалгааны тоо	ДГХБО-ын ОУСТ-ийн чадавхи бэхжээгүй	ДГХБО-ын ОУСТ нь хүний нөөц болон санхүүгийн хувьд хангалттай бэхжсэн байх, бодлогын хэлэлцүүлэгт хэрэглэх 5 судалгаа хийсэн байх.	Хэрэгжилт нь 2014 оноос эхэлж байна.
<b>Үр дүн</b>	<b>Хүрэх түвшин</b>		<b>Одоогийн түвшин</b>
<b>Үр дүн 1:</b> Үндэсний бодлого төлөвлөлтийн систем сайжирсан байна.	Урт болон дунд хугацааны төлөвлөлтийг сайжруулах, уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх-МХЗ-ын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд ҮХЦБ-ын хэрэгжилтийн хүрээнд тэргүүлэх чиглэлийг тогтоох, үйл ажиллагааны төлөвлөгөөг төсөв болон хяналт шинжилгээ, үнэлгээтэй нь уялдуулах чадавхийг бэхжүүлнэ.		Эдийн засгийн хөгжлийн яаманд хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийг боловсруулахад тусласан. Энэ хүрээнд хэлэлцүүлэгт 1000 орчим төрийн албан хаагчид, мэргэжилтнүүд оролцсон байна. Засгийн газар уг хуулийг 3-р сард УИХ-д өргөн барихаар төлөвлөж байгаа бөгөөд хаврын чуулганаарбагтаан батлуулах зорилт тавин ажиллаж байна.
	Хөгжлийн төлөвлөлтийн удирдамжийг боловсруулна.		Хөгжлийн бодлого болон төлөвлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөлт, хяналт, үнэлгээ хийх удирдамж нь 2014 онд бэлэн болно. Энд байгаль орчны асуудлыг тусгана.
	Хэрэгжилт хоцрогдолтой МХЗ-ын “оношлох” судалгааг хийнэ. (Ядуурал, жендэрийн тэгш байдал, ус, ариун цэврийн байгууламж гэх мэт)		Хэрэгжиж дууссан. Үндэсний МХЗ-ын 5 дахь тайланд МХЗ-ын хэрэгжилтийн явцыг хурдасгахад чиглэсэн бодлогын зөвлөмжүүд гарсан.
	Бодлогын судалгаанууд хийгдсэн байна. (МХЗ-ын хэрэгжилтийн үндэсний илтгэл, ядуурлын зураглал, МХЗ-ын хэрэгжилт, ядуурлыг бууруулах, дунд давхаргыг тэлэх чиглэлээр хийгдсэн бодлогын бичиг баримтууд).		МХЗ-ын 5 дахь тайлан; МХЗ-ууд болон ядуурлын зураглал гарч бодлого боловсруулах явцад мэдээллээр хангаж байна. МХЗ-уудын үнэлгээг 2014 оны эхний улиралд гаргана.

	Тоо мэдээлэлд анализ шинжилгээ хийх чадавхи бэхжсэн байна (макро эдийн засгийн загварчлал, “ногоон” ДНБ)	Т-21 макро эдийн засгийн загвар боловсруулсан, Т-21 загварыг ногоон эдийн засаг, тогтвортой хөгжлийн салбарт хэрэглэх талаар анхан шатны ажил хийгдэж байна. "Чингис бонд"-ийн үр нөлөө, хүн амын өсөлт, болон ДНБ-ий өсөлт дэх нийгмийн салбар зэрэг асуудалд анализ дүн шинжилгээ хийх ажил явагдаж байна.	
<p><b>Үр дүн 2:</b> Ядуурлыг бууруулах бодлого хөтөлбөр боловсруулах чадавхийг бэхжүүлнэ, Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (ЯБҮХ) боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.</p>	<p><b>Жендэрийн тэмдэглэгээ 1:</b> Хэрэгжилт хоцрогдолтой МХЗ-ын “оношлох” судалгааг жендэрийн тэгш байдал дээр хийнэ; Бодлогын судалгаануудад жендэр анализ хийгдэнэ; Хөгжлийн төлөвлөлтийн удирдамжид жендэрийн нөлөөллийг авч үзнэ.</p>	Жендэрийн тооцоолол хангалттай хэмжээнд хамрагдахгүй байна. 2014 оны ажлын хөтөлбөрт МХЗ-ууд дээр тулгуурлан энэ асуудлаар тусгайлсан ажил бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөж байна.	
	Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулна. Үүнд: байгалийн баялгаас орж буй орлогыг ядуурлыг бууруулах, хүний хөгжлийг хангахад хэрхэн үр ашигтай ашиглах талаар тусгаж өгнө.	Ядуурлыг бууруулахад чиглэсэн ажлыг үнэлэх, үндэсний хөтөлбөр боловсруулах шаардлага байгаа эсэхийг судлах ажлын хэсэг байгуулагдсан. НҮБХХ-өөс энэ ажлын хэсэгтэй хамтран ажиллана.	
	Ядуурлыг бууруулах Засгийн газрын бодлогод нэмэр болгох гэж амьжиргааг дэмжих төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийгдсэн байна.	Хэрэгжиж дууссан. Ядуу эмзэг бүлгийн хүн ам, жижиг дунд аж ахуйн нэгжид хүрч ажилласан 2 төслийг амжилттай хэрэгжүүлж дуусав.	
	1) Нийгмийн даатгалын системийг шинэчлэх (Монголд бичил даатгал туршилтаар нэвтрүүлэх) замаар нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулна. Нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлснээр Үндэсний нийгмийн хамгааллын хөтөлбөр сайжирсан байна.	Нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр бичил даатгалын салбарыг өргөжүүлэхэд туслах тал дээр НҮБХХ-ийн оролцоо хягаарлагдмал байна.	
	Хүний хөгжилд тулгарч буй амин чухал асуудлуудад бодлого, шийдвэр гаргагчдын анхаарлыг хандуулах, улмаар хүний хөгжлийн талаарх олон түмний ойлголтыг нэмэгдүүлэхэд Хүний Хөгжлийн Үндэсний Илтгэл чухал үүрэг гүйцэтгэсэн байна;	"Залуучууд ба хөгжил" хүний хөгжлийн үндэсний 6-р илтгэлийн бэлтгэл ажил эхэлсэн.	
<p><b>Жендэрийн тэмдэглэгээ 2:</b></p>			

	ЯБҮХ-т жендэрийн тэгш байдлыг болон үүний хяналтыг бодитой тусгуулна. Жендэрийн тэгш байдалтай холбоотой тодорхой ажил хийгдэнэ. ҮХХИ-д жендэр анализ хийгдэнэ.		
<b>Үр дүн 3:</b> Хөгжиж байгаа орнуудын хамтын ажиллагааны хүрээнд ядуурлыг бууруулахад чиглэгдсэн худалдааны бодлогод дэмжлэг үзүүлнэ.	НҮБХХ Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын (ДГХБО) засгийн газруудад зуучлах Олон Улсын Судалгааны төвийн мэдлэгт суурилсан бодлогын зөвлөмж боловсруулах чадавхийг сайжруулна.	Тус судалгааны төвийг үүсгэн байгуулах болон албажуулах ажилд НҮБХХ дэмжлэг үзүүлсэн. Одоо, НҮБХХ /ГХЯ төсөл хэрэгжсэнээр энэ туслалцаа улам эрчимжинэ.	
	Монгол улсын бүс нутгийн хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. (Тухайлбал Түмэн голын төсөл, CAREC);	Түмэн голын санаачлагыг НҮБХХ дэмждэг. Хилийн менежментийн асуудлаар бас туслалцаа үзүүлж байна.	
	<b>Жендэрийн тэмдэглэгээ 1:</b> Бодлогын судалгаануудад жендэрийн анализ хийгдэнэ.		

<b>НҮБХТХ-ийн үр дүн: 2</b>		<b>Хүний эрхийг хамгаалж, ялгаатай байдлыг багасгах засаглал бэхэжсэн байна.</b>	
<b>Үр дүнгийн шалгуур үзүүлэлт</b>	<b>Суурь үзүүлэлт</b>	<b>Хүрэх түвшин</b>	<b>Одоогийн түвшин</b>



Авлигын индексийн харьцангуй түвшин	Монгол улс дэлхийн 183 орноос 120-д жагссан. (Transparency International 2011), МХЗ9 24-10: Авлигын индекс 0.64 (2009)	Монгол Улсын эрэмбэ байр 2016 он гэхэд урагш ахисан байна. (CPI/Transparency 2016); МХЗ 9 авлигын индекст эерэг өөрчлөлт гарна.	Монгол улсын ХҮИ 2011 онд 120 байснаа 2013 онд 83 болж өөрчлөгдсөн.  Монгол улсын олон улсын авилгын үзүүлэлтэнд эзэлдэг байр 2011 онд 120 байснаа 2013 онд 83 болж дээшилжээ.
Хүний эрхийн хэрэгжилтэд нааштай өөрчлөлт гарсан байна.	UPR/2010, CEDAW/2008, CAT/2010, ECOSOC/2010, CCPR (2011)	Хүний эрхийн хэрэгжилтийн талаар дээрх гэрээнүүдийн дүгнэлтэд ахиц гарсан байна.	2015 онд UPR (Universal Periodic Review)-ын тайлан, 2014 онд Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн тайлан тус тус гарна.
УИХ, орон нутгийн хурал, засгийн газарт эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдсэн байна.	УИХ-д 3.9 %, аймаг, нийслэлд эмэгтэй засаг дарга, хурлын байхгүй, 30.2% сум, дүүргийн хуралд, 6.6% Засгийн газрын танхимд	МХЗ 3: Парламентад 30% суудал, орон нутгийн хурал 15%	УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 14.5% болон өсөж, орон нутгийн иргэдийн хуралд эмэгтэй сонгогдсон төлөөлөгчдийн эзлэх хувь 2012 онд 27.3% болж буурсан байна. Засгийн газарт эмэгтэйчүүдийн эзлэх хувь 15.8% болж өссөн.
<b>Үр дүн</b>	<b>Хүрэх түвшин</b>		<b>Хэрэгжилт</b>
<b>Үр дүн 1:</b> Нийгмийн үйлчилгээг хүргэх, олон нийтээс ирсэн асуудалд хариу өгөхийн тулд орон нутгийн байгууллагуудын чиг үүрэг, санхүүжилтыг идэвхжүүлсэн байна.	Орон нутгийн засаг захиргааны хариуцлага болон төрийн үйлчилгээ сайжруулах чиглэлд төлөөллийн болон хяналтын үүргээ биелүүлэх асуудлаар иргэдийн төлөөлөгчдийн хурлын чадавхийг дээшлүүлэх.		Швейцарийн хөгжлийн агентлаг (SDC) засаглал болон төвлөрлийг сааруулах хөтөлбөрийг 2012 оны 4-р сараас хэрэгжүүлж эхэлсэн. Тус хөтөлбөрийн үндсэн зорилго төвлөрлийг сааруулах үндэсний стратеги юм. Төрийн албаны ажил үүргийн хувиарлалтын талаарх судалгаа хийхээр төлөвлөж байна. НҮБХХ-ийн харьцангуй давуу тал нь орон нутгийн хурлуудыг дэмжих асуудал байна хэмээн тодорхойлсон. Энэ ажлаар

		<p>дамжуулан төвлөрлийг сааруулах үндэсний стратегид НҮБХХ дэмжлэгээ үзүүлж байгаа болно.</p>
		<p>Монгол улсын УИХ-аас хэрэгжүүлж буй "Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх" төслийг 2013 онд боловсруулан баталж, хэрэгжүүлж эхлээд байна. Уг төсөл нь орон нутгийн түвшинд бүх сонгогдсон төлөөлөгчдөд сургалт явуулах ба сургалтын модулиудыг боловсруулах болон сургалтын байгууллагуудын чадавхийг сайжруулах замаар тус сургалтыг албан ёсны болгох ажлыг төслийн хүрээнд хийнэ. Төсөл нь орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлж бөгөөд хурлын хяналтыг сайжруулах зорилттой ажиллаж байна. Эндээс гарах сургамж нь орон нутгийн засаглалын хууль эрх зүйн орчин сайжрахад туслах юм.</p>
	<p><b>Жендэрийн тэмдэглэгээ 1:</b> Зорилтот сонгогдсон эмэгтэйчүүдийн төлөөлөгчид</p>	<p>Нийслэл, дүүрэг, аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2200 эмэгтэй төлөөлөгчдийг хамруулан (нийт 8078 төлөөлөгч) удирдлагын сургалтыг явуулах.</p>

<p><b>Үр дүн 2:</b> Хариуцлага, оролцоо, төлөөллийг сайжруулах зорилгын хүрээнд парламент болон сонгуулийн удирдах байгууллага үндсэн үйл ажиллагаагаа явуулах чадавхитай байна.</p>	<p><u><b>Санал болгож буй шинэ үр дүн</b></u></p> <p>Баримт мэдээлэлд тулгуурласан бодлого боловсруулах, олон нийтийн хэлэлцүүлгийн тал дээр УИХ-ын чадавхи нэмэгдсэн байна.</p>	<p>2012 оны аравдугаар сард НҮБХХ-ийн Нью-Йорк дахь төвийн Хөгжлийн Бодлогын газраас төлөөлөгч ирж шинэ засгийн газрын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан НҮБХХ-ийн засаглалын хөтөлбөрт үнэлгээ хийсэн. Энд бодлогын судалгаа, олон нийттэй зөвлөлдөх, асуудлыг улс төрийн үүднээс хардаг явдлыг зогсоох зэргээр хууль тогтоох явцын чанарыг дээшлүүлэх шаардлагатай байгааг цохон тэмдэглэсэн. Төрийн албыг мэргэшүүлэх асуудал мөн тусгагдсан. Энэ үнэлгээ зөвлөмжинд үндэслэн иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь, мөн Иргэн төвтэй мэргэшсэн төрийн алба бий болгох гэсэн хоёр төслийн бичиг баримт боловсруулсан. Зөвлөмжид тодорхойлсон хэрэгцээ шаардлагыг доор шинээр санал болгож буй үр дүн илүү тодорхой харуулах юм.</p>	
		<p>Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь төсөл бодлогын хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийх, нээлттэй хэлэлцүүлэг хийх зэргээр хууль боловсруулах явцыг сайжруулах, НҮБ-ын АЭК-ын хэрэгжилтийгүнэлэхх, ёс зүйн болон сонирхлын зөрчлийн талаар бодлого, эрх зүйн байдлыг сайжруулах, сонгосон</p>	

		төлөөлөгчидтэй харилцах иргэдийн харилцааг нэмэгдүүлэх зэрэг зорилго тавин ажиллаж байна.	
	<p><b><u>Санал болгож буй шинэ үр дүн:</u></b></p> <p>Олон нийтэд үйлчлэх үндсэн үүргээ гүйцэтгэхэд төрийн албан хаагчдын мэргэжлийн үр чадвар сайжирсан байна.</p> <p>Шалгуур үзүүлэлт: төрийн үйлчилгээний талаарх олон нийтийн итгэл нэмэгдсэн байх</p>	<p>Төсөл нь төрийн албыг шинэтгэх талаарх бодлогын түвшинд мэтгэлцээн хэлэлцүүлэг өрнүүлэх, шинэтгэлийн сонголт хийгдэж хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулсаны дараа төрийн албан хаагчдын чадавхийг холбогдох чиглэлээр бэхжүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Төрийн захиргааны гүйцэтгэлд иргэдийн хяналт тавих арга зүйг боловсруулах, хэрэгжүүлэх тал дээр ажиллана.</p>	
	<b><i>Жендэрийн тэмдэглэгээ 2:</i></b> Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар хүний нөөцийн удирдлагын бодлого, үйл ажиллагааг сайжруулах		
<b>Үр дүн 3:</b> үр дүн 2-той нэгтгэх	Сонгуулийн шинэтгэлд техникийн туслалцаа үзүүлэх;	Өмнөх сонгуулийн үеэр онгуулийн шинэтгэлийн асуудлаар дэмжлэг үзүүлсэн.	
	Маргаан шийдвэрлэх механизмыг сайжруулах;	Сонгуулийн захиргааг бэхжүүлэх төсөл 2012 онд хэрэгжсэн.	
	Сонгогчийн болон иргэний боловсролын хөтөлбөрийг залуучуудад түлхүү чиглүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх;		
	Эмэгтэйчүүд сонгогч ба нэр дэвшигч кампанит ажлыг хэрэгжүүлэх;	Сонгуулийн тогтолцоонд төлөөлөл, оролцоог сайжруулах төсөл хэрэгжсэн. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих зургаан зорилтот үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахад УИХ-ын эмэгтэй гишүүдтэй НҮБХХ	

		хамтран ажилласан. Энэ талаар 2014 онд дараагийн сонгуульд зориулан шинэ хөтөлбөр боловсруулна.	
	Шийдвэр гаргах үйл явцад залуучуудын сүлжээний оролцоог дэмжих	Иргэний боловсролоор дамжуулан залуучуудыг эрх мэдэлжүүлэх, чадавхижуулах төслийн хүрээнд Иргэний боловсролын төв, МОНФЕМНЕТ-тэй хамтран ажиллаж байна.	
	<b>Жендэрийн тэмдэглэгээ 3:</b> УИХ, орон нутгийн хуралд эмэгтэйчүүдийн төлөөллийг хангах асуудал тэргүүн зорилт байна.	Энэ тал дээр Засгийн газартай хамтран НҮБХХ амжилттай ажиллав. Эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдэж, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд НҮБХХ дараагийн сонгуульд энэ чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах болно.	
Үр дүн 5-тай нэгтгэх	Ядуурлыг бууруулахад эрх зүйн саад тотгорыг тогтоосон судалгаа хийх;	2011-2012 онд хууль зүйн яамтай хамтран төлбөрийн чадваргүй ядуу иргэдийн эрхзүйн чадамжийг сайжруулах чиглэлээр ажилласан. Өмчлөл, хувиар бизнес эрхлэх, хөдөлмөрлөх эрх, засгийн газрын төсөл хөтөлбөр болон захиргааны шийдвэр ядуу иргэдэд нөлөөлөх байдал сэдэвт асуудлаар судалгаа хийж үр дүнг нь олон оролцогчдын хамарсан хурал дээр	
	Албан бус салбар, жижиг бизнес эрхлэх өртөг зардлыг тогтоох суурь судалгаа хийх		

	<p>Хууль эрх зүйн шинэчлэл, захиргааны үйл ажиллагаанд өөрчлөлт хийх талаар зөвлөмж гаргах</p> <p><i>Санал болгож буй өөрчлөлт :</i> Төслийн үр дүнг тусган дээр нэмэх</p>	<p>тайлагнан хэлэлцүүлсэн. Засгийн газрын тэргүүлэх чиглэл өөрчлөгдсөнтэй холбогдох энэ чиглэлээрх дараагийн төсөл боловсруулаагүй болно.</p>
	<p><b>Жендэрийн тэмдэглэгээ 2:</b> Эрх зүйн судалгаа хийх явцад жендэрийн дүн шинжилгээг хийнэ.</p>	<p>Хэрэгжиж дууссан.</p>
<p><b>Үр дүн 3:</b> Хүний эрхийн байгууллагуудын чадавхи сайжирсан байна</p>	<p>Олон улсын хүний эрхийн байгууллагад тайлагнах ХЭҮК-ийн судалгааны чадавхи сайжирсан байна.</p> <p>Хүний эрхийн хяналт сайжирсан байна.</p> <p>Хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэх эрх зүйн орчин бий болсон байна.</p> <p>Хүний эрхийн зөрчлийн талаар гомдол шийдвэрлэх механизм сайжирсан байна.</p> <p>Шинээр үүсч бий болж буй Хүний эрхийн асуудлаар бодлогын нөлөөлөл хийнэ.</p>	<p>Зорилго нь Монгол Улсын өнөөгийн хөгжлийн хүрээнд шинээр бий болж буй хүний эрхийн асуудлууд, тодорхой бүлэгт нөлөөлж буй асуудлуудыг судалж тайлагнах, бодлогын мэтгэлцээн, олон нийтийн боловсролын асуудлаар холбогдох байгууллагуудтай ажиллах замаар үндэсний хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих механизмыг бэхжүүлэх явдал юм.</p>
	<p><b>Жендэрийн тэмдэглэгээ 2:</b> Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх явдлыг нэн тэргүүнд авч үзнэ.</p>	<p>Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулинд хяналт тавих чадавхийг бэхжүүлж ажиллав.</p>

<b>НҮБХТХ -ийн үр дүн: 3</b>		<b>Байгалийн нөөцийн менежментийн тогтвортой байдал, уур амьсгалын өөрчлөлтөд экосистем ба эмзэг бүлгийнхний дасан зохицох чадавхийг сайжирсан байна.</b>	
<b>Шалгуур үзүүлэлт:</b>	Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ, усны хамгаалагдсан эх үүсвэр, нэн ховордсон амьтан, ургамлын зүйлийн тоо болон нөхөн сэргээгдсэн газрын хэмжээнд гарсан өөрчлөлт	<b>Одоогийн түвшин:</b>	Тусгай хамгаалалттай газар нутгийн 1% нэмэгдэх зорилтод хүрсэн. Орон нутгийн хамгаалалттай газруудыг оруулж тооцвол энэ хувь 27.69 байна. (МХЗ хэрэгжилтийн тайлан, 2013).
	Гамшиг, ослын тоо болон эдийн засгийн хор хохирлын бууралт		ОБЕГ-с мэдээлэл авах
<b>Гарах үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд</b>	<b>Суурь утга</b>	<b>Зорилт</b>	<b>Хэрэгжилт</b>
Байгаль орчны хууль тогтоомжийн биелэлтийн үр ашиг	Хууль журмын хэрэгжилт хангалтгүй	Байгаль орчинд хохирол учруулсан хэргийн илрүүлэлт 10%-иар өссөн байна.	2011 - 150 хэргийн илрүүлэлт (суурь тоо) 2013 - 165 хэргийн илрүүлэлт
Боловсруулсан/шинэчилсэн болон хүчин төгөлдөр болсон бодлого, хууль тогтоомжийн тоо; орон нутаг дахь гамшгийн эрсдэлийг бууруулах бүлгийн тоо;  Ландшафтад суурилсан байгалийн нөөцийг хамгаалах стратегийн тоо.	Хүчин төгөлдөр бодлого, хууль тогтоомж,эрх зүйн зохицуулалтын механизм хангалтгүй.	Гамшгийн эрсдэлийг бууруулах, Ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр тус бүр 3-аас доошгүй бодлого/эрх зүйн баримт бичгийг шинэчлэх, Ландшафтад суурилсан байгалийн нөөцийг хамгаалах 3 стратеги боловсруулах, гамшгийн эрсдэлийг бууруулах	6 хууль, 12 журам, 1 үндэсний стратеги



		бүлгийн зарчмыг 4 аймагт шинээр нэвтрүүлэх	
Хүлэмжийн хий (ХХ)-н ялгарлыг бууруулахад авч хэрэгжүүлсэн Монгол орны онцлогт нийцсэн арга хэмжээ, Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, дасан зохицох рага хэмжээний талаар хийсэн судалгаа	Засгийн газраас Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг үндсэн 11 чиглэлээр тодорхойлсон.	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээг 3-аас цөөнгүй чиглэлд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицох арга хэмжээг / эмзэг салбар, бүлэгт түлхүү анхаарсан/ тодорхойлох судалгааны тайлан.	Ойн болон барилгын салбарын NAMA буюу Монгол орны онцлогт нийцсэн хүлэмжийн хийг бууруулах арга хэмжээ авахад туслалцаа үзүүлэх ажлыг эхлүүлсэн.
Шинэ буюу шинэчилсэн Эрчим хүчний хэмнэлт, Ус, ариун цэврийн байгууламжийн барилгын норм, дүрэм ба стандартын тоо (БНДБС)	Барилгын норм, стандартын тогтолцоог сайжруулах хэрэгцээний судалгаа хийгдсэн.	Эрчим хүчний хэмнэлтийн 10 БНБДС. Ус, ариун цэврийн байгууламжийн 5 БНДБС-г боловсруулах буюу шинэчилж, хэрэгжилтийг хангах	Эрчим хүчний хэмнэлтийн 4 норм, 25 стандарт, усны болон ариун цэврийн хувьд нийт 1 норм, 6 стандарт боловсруулсан.
<b>Үр дүн</b>	<b>Зорилт</b>		<b>Хэрэгжилт</b>
<b>Үр дүн 1:</b> Хуулийн хэрэгжилтийг сайжруулахад түлхүү чиглэсэн байгаль орчны бодлогын шинэчлэлийг дэмжих.	Байгаль орчны хууль эрх зүйн орчныг шинэчлэх болон сайжруулах төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх		33 хуулийн 18-ыг 8-руу нэгтгэж, 2 шинэ хууль батлуулсан нь хуулийн алдаа дутагдлыг шийдвэрлэхэд болон давхардал, зөрчилтэй заалтуудыг арилгахад гаргасан томоохон амжилт байлаа. Шинээр батлагдсан хууль багц хэрэгжилтийг идэвхжүүлэхийн тулд 100 орчим журам, хэрэгжүүлэх заавар, аргачлал боловсруулж бэлэн болгосон.
	Ногоон хөгжлийн үндэсний стратеги боловсруулахад дэмжлэг үзүүлэх		Эдийн засгийн гол салбаруудын ногоон эдийн засгийн нөөц бололцоог тодорхойлоход шаардлагатай нарийн судалгаанууд, хэд хэдэн олон

		улсын болон хоёр талын хамтран ажиллах гэрээнүүд байгуулсан бөгөөд үүнд Дэлхийн Ногоон Өсөлтийн Санаачлага, Японы “Хамтарсан кредит олгох механизм” зэргийг дурьдаж болно. Ногоон хөгжлийн бодлогын хэд хэдэн арга хэмжээг салбар дундын болон яамд хоорондын хамтын ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлсэн.
	Байгаль орчны стратеги үнэлгээ болон БО-ны аудитыг нэвтрүүлэх ажлыг дэмжих	Холбогдох заавар, аргачлалуудыг албан ёсоор улсын хэмжээнд батлуулах, аудит хийх албан газрыг томилуулах, байгаль орчны аудиторуудад зориулсан сертификат олгох сургалт явуулах зэрэг үйл ажиллагааны хүрээнд энэ зорилтыг хангасан.
	Байгаль орчинд ээлтэй уул уурхайг хөгжүүлэхэд зардал үр ашгийн дүн шинжилгээний аргачлалыг боловсруулах	Байгаль орчны засаглал төслийн хүрээнд байгаль орчинд ээлтэй уул уурхайг хөгжүүлэхэд зардал-үр ашгийн дүн шинжилгээний модель аргачлал болон уур амьсгалын өөрчлөлтийн эрсдлийн дүн шинжилгээг хийж боловсруулсан.
	Байгаль орчны ТББ-уудын чадавхийг бэхжүүлэх стратеги боловсруулах	НҮБХХ-ийн байгалийн нөөцийн ТББ-ын удирдлагын албан ёсны гэрээ дэмжих нь амжилттай болсон. 2014 онд ажиллана.
	<b>Жендэрийн тэмдэглэгээ 1:</b> Бодлого, стратегид жендэрийн тэгш байдлыг тусгасан байна	Жендэрийн тэгш байдлын асуудлыг хангалттай тусгаагүй байна. 2014 онд энэ асуудлыг эксперт шинжээчээр судлуулах саналыг НҮХХХ-өөс тавьж байгаа.
<b>Үр дүн 2:</b> Бэлчээр, газар, усны нөөц, болон биологийн олон янз байдлын менежментийг ландшафтад	Төрийн албан хаагчдын /ялангуяа сумын түвшинд/ байгалийн баялгийн тогтвортой менежментийн чадавхийг сайжруулах	Газрын агентлаг, институцууд, орон нутгийн газар, байгаль орчин, бэлчээрийн менежмент хариуцсан албан хаагчдын судалгааны болон газар ашиглалтын төлөвлөлт, орчин үеийн, стандарт арга техникийг ашиглах чадавхийг бэхжүүлсэн.

тулгуурласан төлөвлөлтийн зарчимд үндэслэн сайжруулах	Ландшафтад тулгуурласан төлөвлөлтийн зарчимд үндэслэсэн газар ашиглалтын төлөвлөгөөг загварчлан хэрэгжүүлэх;	Сум, газрын ажилтнууд arc/gps болон газрын менежментийн програм хангамж ашиглах аргачлалд сургасан.
	Тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтийн бие даасан болон шинэлэг арга хэлбэрийг загварчлан хэрэгжүүлэх	Тусгай хамгаалалттай газар нутагт (ТХГН) нэвтрэх хураамжийн төлбөрийн шинэ журам боловсруулж БОНХЯ болон Сангийн яаманд хүргүүлэв. ТХГН-ийн орлогын тодорхой хувийг нисэх онгоцны бүүдлын албан татвараас олсон орлогоор хангах боломжуудыг судлах ажил явагдаж байна. Концессын гэрээгээр дамжуулан ТХГН-ийн торгуулийн арга хэмжээний хувилбаруудыг судлах судалгааны ажил хийгдэж байна.
	Нөөцийн зохицуулалт бүхий тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг нэвтрүүлэх	Ажил эхэлсэн, энэ талаарх үйл ажиллагаа эхлэлийн шатандаа явагдаж байна.
	REDD+-ийг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг дэмжих	REDD+ хөтөлбөрт бэлтгэх Үндэсний төлөвлөгөөг боловсруулж тодорхой зорилтот дэмжлэгүүдийн хүрээнд хэрэгжилтийн ажлыг эхлүүлээд байна. Ойн экосистемийн эдийн засгийн үнэлгээг хийснээр ойн салбарын төсвийн хуваарилалтыг 2014 он гэхэд бараг хоёр дахин нэмэгдүүлэхэд туслалцаа болсон. НҮБ-REDD хөтөлбөрөөр дамжуулан ойн нөөцийн олон зорилтот тооллогын системийг нэвтрүүлсэн бөгөөд 2014 онд батлуулах зорилт тавин ажиллаж байна.
	Байгалийн баялгийн ашиглалтанд тавих хяналтад орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх төслийн зорилтот хоёр газарт удирдлагын зөвлөлийг байгуулснаар орон нутгийн

		засаг захиргаа болон орон нутгийн иргэдтэй хамран ажиллах шинэлэг арга барилыг нэвтрүүлсэн. Байгалийн нөөцийн нэгдсэн менежментийн нутгийн иргэдэд түшиглэсэн арга барилыг Газрын тогтвортой менежмент төслийн 13 зорилтод сумдад амжилттай туршиж хэрэгжүүлсэн. Малчдын бүлэг байгуулагдаж бэлчээрийг сэлгэн ашиглах арга барилыг хэрэгжүүлж байхаар тохиролцсон.	
	<b>Жендэрийн тэмдэглэгээ 1:</b> Байгалийн баялгийн менежментэд нөөцийн зохицуулагчид болох эмэгтэйчүүдийн санал бодлыг тусгах ба загвар үйл ажиллагаанд хүйсийн тэгш байдлыг хангана.	Жендэрийн тэгш байдлын асуудлыг хангалттай тусгаагүй байна. 2014 онд энэ асуудлыг эксперт шинжээчээр судлуулах саналыг НҮХХХ-өөс тавьж байгаа.	
<b>Үр дүн 3:</b> Уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдлийн менежментийн салбар хоорондын зохицуулалт, харилцаа холбоо, мэдээлэл солилцооны чадавхийг бэхжүүлэх.	Онцгой байдал хариуцсан төрийн байгууллагын үүрэг хариуцлагыг тодотгож, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох	2014 онд явагдаж буй ажил	
	Байгалийн болзошгүй гамшигт болон аюулт үзэгдлээс сэргийлэхийн тулд онцгой байдлын менежментийн байгууллагуудын хүн болон техникийн чадавхийг сайжруулах	Гамшгийн эрсдэлийг бууруулах төслийн хүрээнд ажил эхлээд явж байна	
	Цаг агаараас үүдэлтэй аюулт үзэгдлийг ажиглах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх, мэдээлэх системийг сайжруулах	Ажил эхэлсэн	

	Иргэдэд түшиглэсэн уур амьсгалын болон гамшгийн эрсдлийн менежментийг хот суурин газар болон орон нутгийн онцлогт тохирсон хэлбэрээр нэвтрүүлэх	Гамшгийн эрсдэлээс хамгаалах орон нутгийн чадавхийг бэхжүүлэх төсөл батлагдсан.
	<b>Жендэрийн тэмдэглэгээ 1:</b> Гамшгийн эрсдлийн менежментийн системийг сайжруулахад жендэрийн үзэл баримтлалыг бүх шатанд тусгана, учир нь эмэгтэйчүүд гамшгийн дараа ихэвчлэн бусдад анхаарал тавих ба гамшгийн эрсдлийн бэлэн байдалд эерэг нөлөөтэй	Жендэрийн тэгш байдлын асуудлыг хангалттай тусгаагүй байна. 2014 онд энэ асуудлыг эксперт шинжээчээр судлуулах саналыг НҮХХХ-өөс тавьж байгаа.
<b>Үр дүн 4:</b> Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөлд эмзэг салбар болон бүлгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бэхжүүлэх	Экосистемийн үйлчилгээг дэмжихэд чиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодит арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх	Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээ (EBA) төслийн хүрээнд ажил үргэлжилж байна.
	Уур амьсгалын өөрчлөлтийн зохицуулах албаны чадавхийг бүтцийн хувьд сайжруулах стратегийг боловсруулан, хэрэгжүүлэх	Шинээр баталсан Ойн тухай болон Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиудын хэрэгжилтийг хангах үүднээс 6 журамыг сайжруулж мөн шинээр батлуулах ажил хийгдсэн.  Гол гол байгууллагуудын (БОНХЯ*, Уур амьсгалын өөрчлөлтийн Үндэсний Хороо, Уур амьсгалын өөрчлөлтийн алба болон Ус цаг уур орчны шинжилгээний алба зэрэг) хөгжлийн бодлого, төлөвлөлтөд EBA арга барилыг нэвтрүүлэх үндэсний чадавхийг бэхжүүлэх талаар үнэлгээний ажил хийгдсэн.  Хоёр зорилтод бүс нутагт хоёр голын сав газрын удирдлага байгуулагдаж, үйл ажиллагаа нь жигдрээд байна. Эдгээр сав газарт 2014 хэрэгжүүлэх усны нөөцийн нэгдсэн удирдлагын төлөвлөгөөг боловсруулж дууссан. Олон нийт болон шийдвэр гаргагчдад зориулсан гарын авлага боловсруулж сургагч багш нарыг бэлтгэв.
	Уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицох арга хэмжээний зардал үр ашгийн тооцоо хийнэ. Үүнд эмзэг бүлгийг онцгойлон анхаарна.	Ажил эхэлсэн.

	Хүлэмжийн хийн тооллогод шаардлагатай мэдээ цуглуулах болон тооцоолох аргачлалыг сайжруулах	Ажил эхэлсэн.
	Ашгийн ба ашгийн бус барилгын салбарт эрчим хүчний хэмнэлттэй үйл ажиллагааг дэмжсэн БНДБС-г боловсруулах, шинэчлэх	Барилгын 6 норм болон 60 стандартыг сайжруулан болон шинээр боловсруулсан (үүнээс 3 норм болон 12 стандарт шинэ). Барилгын бүх зураг төслүүд эдгээр шинэ стандартын дагуу хийгдэж холбогдох засгийн газрын байгууллагаар баталгаажуулагдах ёстой. Нийт 223 шинэ хувийн орон сууцны барилгыг НҮБХХ-н төслийн дагуу боловсруулсан инженер техникийн зураг төслийн дагуу барьж ашиглалтанд оруулсан байна. Давуу тал нь эдгээр барилгыг халаах түлшний зардал даруй хоёр дахин бага байх юм.
	<b>Жендэрийн тэмдэглэгээ 1:</b> Гэр бүлийн болон нийгмийн тогтвортой байдал эмэгтэй хүнээс шууд хамаардаг тул дасан зохицох арга хэмжээг хүйсийн тэгш байдлыг харгалан хэрэгжүүлнэ	Жендэрийн тэгш байдлын асуудлыг хангалттай тусгаагүй байна. 2014 онд энэ асуудлыг эксперт шинжээчээр судлуулах саналыг НҮБХХ-өөс тавьж байгаа.
<b>Үр дүн 5:</b> Баталгаат үндны ус болон ариун цэврийн байгууламжийн хүртээмжийн тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн шинэлэг, хэмнэлттэй технологийг бий болгох	Үндэсний статистикийн газартай хамтран Үндэсний Ус Хангамж, ариун цэврийн байгууламжийн мэдээллийн санг бий болгон ажиллуулна	НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр ус, ариун цэврийн үйлчилгээг үндэсний статистикийн албаны мэдээлэл цуглуулах системд бүрэн оруулсан байна
	Батлагдсан БНДБС-ын дагуу жижиг сууринд зориулсан шинэлэг, өртөг багатай ариун цэврийн байгууламжийн технологийг бий болгоно;	НҮБХХ-ийн боловсруулж засгийн газраас баталсан моно төрлийн зураг төлөвлөгөөний дагуу хийсэн ус хангамж болон ариун цэврийн нэгдсэн системийг хоёр сумын төвд байгуулах ажлыг хийсэн.
	Сумын төвүүдэд Нийтийн аж ахуйн менежментийн загварыг бий болгоно	Ус ариун цэврийн байгууламжийн тогтвортой үйлчилгээг хангах, байгууламжийн ашиглалт засвар үйлчилгээг хариуцах талаар Сумын захиргаа, аймгийн Барилга хот байгуулалтын газар болон Орон сууц, нийтийн аж ахуйн газар хооронд гурвалсан гэрээ байгуулах замаар удирдлага зохион байгуулалтын шинэ бүтцийг танилцуулсан. Энэ загвар нь төр болон хувийн хэмшлийн хамтын

		ажиллагааг бэхжүүлэх болон сумын түвшинд нийтийн байгууламжийн менежмент удирдлагыг хангах хамгийн тохиромжтой загвар болсон.	
	Шинэ техник, технологийг нэвтрүүлэхэд салбарын ажиллах хүчний чадавхийг сайжруулна	Сумын холбогдох албан тушаалтан ажилтнууд, байгууламжийг хариуцсан хүмүүс болон орон сууц нийтийн аж ахуйн газрын ажилтнуудад ус ариун цэврийн байгууламжийн ашиглалт засвар үйлчилгээний талаар сургалт зохион байгуулсан.	
	<b>Жендэрийн тэмдэглэгээ 2:</b> Баталгаат үндны ус болон ариун цэврийн байгууламжийн хүртээмж нь Мянганы Хөгжлийн Зорилтуудад хүрэх суурь болох тул ус, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээний хамрах хүрээний тэгш бус байдлыг бууруулахад анхаарах болно.	Жендэрийн тэгш байдлын асуудлыг хангалттай тусгаагүй байна. 2014 онд энэ асуудлыг эксперт шинжээчээр судлах саналыг НҮХХХ-өөс тавьж байгаа.	
Financial delivery	<b>Үндсэн эх үүсвэр</b>		
	<b>Бусад эх үүсвэр</b>		

## Хавсралт 2: Хөрөнгө зарцуулалтын байдал, 2012-2013, ам. доллар

Үр дүн	Санхүүгийн эх үүсвэр	2012	2013 (урьдчилсан тооцоогоор)	Нийт
<b>Үр дүн 1: Эдийн засгийн хөгжлийн үр шимийг тэгш хүртээх замаар ядуурлыг бууруулах</b>				
Үр дүн 1-ийн хүрээнд гарсан зардал	НҮБХХ	571,866	547,532	1,119,398
	Бусад	584,977	641,057	1,226,034
	Нийт	1,156,843	1,188,589	2,345,433
<b>Үр дүн 2: Хүний эрхийг хамгаалж, ялгаатай байдлыг багасгах засаглал бэхэжсэн байна</b>				
Үр дүн 2-ын хүрээнд гарсан зардал	НҮБХХ	610,344	673,258	1,283,602
	Бусад	266,452	475,862	742,314
	Нийт	876,795	1,149,121	2,025,916
<b>Үр дүн 3: Байгалийн нөөцийн менежментийн тогтвортой байдал, уур амьсгалын өөрчлөлтөд экосистем ба эмзэг бүлгийнхний дасан зохицох чадавхи сайжирсан байна</b>				
Үр дүн 3-ын хүрээнд гарсан зардал	НҮБХХ	697,097	929,986	1,627,083
	Бусад	2,290,047	2,575,374	4,865,421
	Нийт	2,987,144	3,505,360	6,492,504
<b>Нийт хөрөнгийн зарцуулалт</b>				
Нийт хөрөнгийн зарцуулалт	НҮБХХ	1,879,306	2,150,777	4,030,083
	Бусад	3,141,476	3,692,293	6,833,769
	Нийт	5,020,782	5,843,070	10,863,852